**Агуулга**


**Монгол улсын нийгэм, эдийн засгийн байдал ....................... 3**

**I. Нийгмийн үзүүлэлт ........................................................ 6**

1. Ажилгүй иргэд ........................................................ 6
2. Нийгмийн даатгал, нийгмийн халамж ................................ 8
3. Эрүүл мэнд ............................................................ 10
4. Гэмт хэрэг .............................................................. 11

**II. Макро эдийн засгийн үзүүлэлт ............................................ 14**

1. Үнэ .......................................................................... 14
2. Мөнгө, зээл, үнэт цаас ............................................... 19
3. Улсын нэгдсэн төсөв.................................................... 23
4. Гадаад худалдаа ......................................................... 24

**III. Үйлдвэрлэл, үйлчилгээ ................................................... 26**

1. Хөдөө аж ахуй ........................................................... 26
2. Аж үйлдвэр ................................................................ 27
3. Дотоод худалдаа ......................................................... 29
4. Тээвэр ....................................................................... 30
5. Зочид буудал, зоогийн газар ......................................... 32
6. Даатгал ..................................................................... 33

**IV. Бусад .......................................................................... 34**

1. Цаг уур, агаарын бохирдолт ........................................... 34

**V. Хавсралт ...................................................................... 36**

**V. Монгол улсын хөгжил олон улсын түвшинд .......................... 50**

**VI. Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм ............ 60**

## Ерөнхий тэмдэглэл

**I. Товчилсон тэмдэглэгээ:**

| | |
|---|---|
| АР | Архангай |
| БӨ | Баян-Өлгий |
| БХ | Баянхонгор |
| БУ | Булган |
| ГО | Говь-Алтай |
| ДО | Дорноговь |
| ДД | Дорнод |
| ДУ | Дундговь |
| ЗА | Завхан |
| ӨВ | Өвөрхангай |
| ӨМ | Өмнөговь |
| СҮ | Сүхбаатар |
| СЭ | Сэлэнгэ |
| ТӨ | Төв |
| УВ | Увс |
| ХО | Ховд |
| ХӨ | Хөвсгөл |
| ХЭ | Хэнтий |
| ДА | Дархан-Уул |
| УБ | Улаанбаатар |
| ОР | Орхон |
| ГС | Говьсүмбэр |

II. ДНБ Дотоодын нийт бүтээгдэхүүн
ААНБ Аж ахуйн нэгж, байгууллага

**Дараах тэмдэглэлүүдийг ашиглав:**

... **мэдээлэл байхгүй**
0.0 **маш бага тоо**
\- **гүйцэтгэл байхгүй.**

## Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал (2012 оны эхний 10 сарын байдлаар)

### I. Нийгмийн үзүүлэлт

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сард 62085 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 62347 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 3418 эхээр буюу 5.8 хувь, хүүхдийн тоо 3450 хүүхдээр буюу 5.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

Улсын хэмжээгээр энэ оны эхний 10 сард нялхсын эндэгдэл 949 болж, өмнөх оны мөн үеийнхээс 16 хүүхэд буюу 1.7 хувь, 1-5 хүртэлх насандаа 206 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхэд буюу 2.4 хувиар буурав.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 10 дугаар сарын эцэст 40.1 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 745 хүнээр буюу 1.9 хувиар өсчээ.

Нийгмийн даатгалд 2012 оны эхний 10 сард 687.0 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 464.6 мянга буюу 67.6 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 222.4 мянга буюу 32.4 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 80.5 мянга буюу 13.3 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 69.2 мянга буюу 17.5 хувь, төсөвт байгууллагынх 11.4 мянга буюу 5.4 хувиар нэмэгджээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны эхний 10 сард 60.6 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 мян.хүн буюу 6.6 хувь, олгосон тэтгэврийн хэмжээ 26.2 тэрбум төг буюу 91.0 хувиар нэмэгджээ.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2012 оны эхний 10 сард вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 4390 хүн буюу 43.4 хувь, салхин цэцгээр 531 хүн буюу 20.2 хувь, цусан суулгаар 59 хүн буюу 3.1 хувь, сүрьеэгээр 67 хүн буюу 1.9 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 45 хүн буюу 1.3 хувиар буурсан хэдий ч энэ оны эхний 10 сард халдварт өвчнөөр өвчлөгчдийн нийт тоо 36073 хүнд хүрч, 2625 хүн буюу 7.8 хувиар нэмэгдсэн нь гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 7129 хүн буюу 9.3 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 400 хүн буюу 11.3 хувиар өссөнөөс голлон шалтгаалав.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сарын байдлаар 18252 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2286 хэргээр буюу 14.3 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1457), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (398), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (187), байгаль хамгаалах журмын эсрэг (147) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Бүртгэгдсэн гэмт хэргийн улмаас 6947 хүн гэмтэж, 800 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 366 буюу 5.6 хувиар өсч, нас барсан хүний тоо 88 буюу 9.9 хувиар буурсан байна.

### II. Макро эдийн засгийн үзүүлэлт

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувь, оны эхнээс 12.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.0 хувиар өслөө.

Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Мөнгөний нийлүүлэлт (М2) 2012 оны 10 дугаар сарын эцэст 7132.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 20.4 тэрбум төг буюу 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1054.3 тэрбум төг буюу 17.3 хувиар өсчээ.

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 10 дугаар сарын эцэст 717.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 28.0 тэрбум төг буюу 3.8 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 22.7 тэрбум төг буюу 3.3 хувиар өсчээ.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 10 дугаар сарын эцэст 6855.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 11.9 тэрбум төг буюу 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1633.5 тэрбум төг буюу 31.3 хувиар өсчээ.

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 10 дугаар сарын эцэст 132.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 15.5 тэрбум төг буюу 13.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 61.5 тэрбум төг буюу 86.6 хувиар өсчээ.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 10 дугаар сарын эцэст 306.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төг буюу 0.03 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 41.3 тэрбум төг буюу 11.9 хувиар буурсан байна.

Үнэт цаасны арилжаа 2012 оны 10 дугаар сард 23 өдөр явагдаж, 665.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 2.1 сая ш үнэт цаас арилжигдсан байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны эхний 10 сард 3942.5 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4521.5 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 579.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Нэгдсэн төсвийн урсгал орлого 2012 оны эхний 10 сард 3904.8 тэрбум төг, урсгал зардал 3423.1 тэрбум төг болж, тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 481.7 тэрбум төгрөгийн ашигтай гарав.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 466.9 тэрбум төг буюу 15.4 хувиар нэмэгдэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 166.5 тэрбум төг буюу 45.5 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 160.0 тэрбум төг буюу 13.7 хувь, бусад татварын орлого 92.0 тэрбум төг буюу 17.1 хувь, орлогын албан татварын орлого 42.1 тэрбум төг буюу 6.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 43.6 тэрбум төг буюу 12.0 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 2.9 тэрбум төг буюу 7.1 хувиар буурсан хэдий ч газрын тосны орлого 20.2 тэрбум төг буюу 41.9 хувь, хүү, торгуулийн орлого 12.2 тэрбум төг буюу 34.2 хувь, бусад нэр заагдаагүй орлого 10.0 тэрбум төг буюу 26.9 хувь, навигацын орлого 2.1 тэрбум төг буюу 6.0 хувь, төсөвт газрын өөрийн орлого 1.2 тэрбум төг буюу 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны эхний 10 сард 4521.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1236.9 тэрбум төг буюу 37.7 хувиар нэмэгдсэн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 206.5 тэрбум төг буюу 83.4 хувиар буурсан хэдий ч хөрөнгийн зардал 505.2 тэрбум төг буюу 91.5 хувь, бараа, үйлчилгээний зардал 475.4 тэрбум төг буюу 43.0 хувь, татаас ба шилжүүлэгийн зардал 398.9 тэрбум төг буюу 29.6 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 64.0 тэрбум төг буюу 3 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Хөрөнгийн зардалд 2012 оны эхний 10 сард 1057.4 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 505.2 тэрбум төг буюу 91.5 хувиар нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 490.1 тэрбум төг буюу 96.2 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 15.0 тэрбум төг буюу 35.4 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

Монгол Улс 2012 оны эхний 10 сард дэлхийн 135 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9404.0 сая ам.долл, үүнээс экспорт 3664.7 сая ам.долл, импорт 5739.3 сая ам.долларт хүрчээ

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 10 сард 2074.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 469.6 сая ам.долл буюу 29.3 хувиар өсчээ. Үүнд импортын өмнөх оны мөн үеийнхээс өссөн өсөлт экспортынхоос 9.4 пунктээр илүү байгаа нь нөлөөлсөн байна.

Нийт бараа эргэлтийн хэмжээ 304.3 сая ам.долл буюу 3.3 хувь, импортын хэмжээ 386.9 сая ам.долл буюу 7.2 хувиар өсч, экспортын хэмжээ 82.7 сая ам.долл буюу 2.2 хувиар буурчээ.

Экспортын 98.2 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн эзэлж байна.

## III. Эдийн засгийн салбарын үзүүлэлт

Улсын хэмжээгээр 2012 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар 470.5 мян.т үр тариа, 245.6 мян.т төмс, 97.8 мян.т хүнсний ногоо хурааж, 1140.0 мян.т хадлан, 33.8 мян.т гар тэжээл, 975.3 т дарш бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төмс 46.3 мян.т буюу 23.2 хувь, үр тариа 25.2 мян.т буюу 5.7 хувиар нэмэгдэж,

харин дарш 1.3 мян.т буюу 2.3 дахин, гар тэжээл 9.3 мян.т буюу 21.5 хувь, хадлан 5.3 мян.т буюу 0.5 хувь, хүнсний ногоо 0.5 мян.т буюу 0.5 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 10 сард 1776.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 104.8 тэрбум төг буюу 6.3 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд 35 хувийн агуулгад шилжүүлснээр зэсийн баяжмал, молибдений баяжмал, металл агуулгаараа, цайрын баяжмал, төмрийн хүдэр, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.6-47.9 хувь; хиаман төрлийн бүтээгдэхүүн, гурил, малын тэжээл, сүлжмэл эдлэл, нарийн боов, архи, хивс, металл цувимал, зүсмэл материал, цэвэр ус, талх, шар айраг, цахилгааны утас, шингэн сүү, малын мах, шахмал түлш, шавардлагын зуурмаг, бетон дэр зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.7 хувиас 4.7 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврээр 2012 оны эхний 10 сард 16894.3 мян.т ачаа тээж, давхардсан тоогоор 3365.0 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1707.3 мян.т буюу 11.2 хувь, зорчигчдын тоо 158.6 мян.хүн буюу 4.9 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 10 сард 347.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 23.6 тэрбум төг буюу 7.3 хувиар өсчээ.

Агаарын тээврээр 2012 оны эхний 10 сард 3385.4 т ачаа тээж, давхардсан тоогоор 654.8 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1141.8 т буюу 50.9 хувь, зорчигчдын тоо 178.0 мян.хүн буюу 37.3 хувиар өсчээ. Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 10 сард 162.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 24.3 тэрбум төг буюу 17.6 хувиар нэмэгдэв.

Аюулт үзэгдэл, осол 2012 оны эхний 10 сард 3367 удаа гарсны улмаас 208 хүн амь насаа алдаж, 12.2 мянган толгой мал, амьтан хорогджээ. Энэ оны эхний 10 сард объектын түймэр 2878 удаа, ой, хээрийн түймэр 218 удаа, гол, нуурын усанд хүн унасан осол 93 удаа, аадар бороо, үерийн үзэгдэл 34 удаа, мал, амьтны халдварт галзуу өвчин 30 удаа, бичил уурхай, нурангины осол 24 удаа, хүчтэй салхи, шуурга 20 удаа, аянгын үзэгдэл 16 удаа, малын халдварт боом өвчин 14 удаа, химийн хорт бодисын алдагдалтай холбоотой ослын дуудлага 10 удаа бүртгэгджээ. Аюулт үзэгдэл, ослын улмаас 91.4 тэрбум төгрөгийн хохирол учирсан байна.

Өмнөх оны мөн үеийнхээс аюулт үзэгдэл, ослын тохиолдол 411-ээр, амь насаа алдсан хүний тоо 19-өөр нэмэгдэв.

Ус, цаг уурын хүрээлэнгийн мэдээгээр хамгийн их хур тунадас 2012 оны 10 дугаар сард Булган аймгийн Сэлэнгэ суманд орж 36.0 мм-т хүрчээ. Энэ оны 10 дугаар сард Ховд аймгийн Зэрэг, Дорнод аймгийн Чойбалсан, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд хамгийн их температур 24.0 хэм, Завхан аймгийн Цэцэн-Уул суманд хамгийн бага температур -30.0 хэм байлаа. Салхины хурд Баян-Өлгий аймгийн Өлгий суманд 25 м/с хүрчээ.

Азотын давхар ислийн хоногийн дундаж агууламж 2012 оны 10 дугаар сард Улаанбаатар хотын 13-р хороолол орчимд 30 удаа, Хархорин захын орчимд 24 удаа, 32-ын тойрог орчимд 16 удаа, Баруун дөрвөн замын орчимд 14 удаа, Офицеруудын ордон орчимд 4 удаа, 1-р хороолол орчимд 2 удаа, хүхэрлэг хийн хоногийн дундаж агууламж 13-р хороолол орчимд 19 удаа, 32-ын тойрог орчимд 9 удаа, Офицеруудын ордон орчимд 8 удаа, 1-р хороолол орчимд 4 удаа, Баруун дөрвөн замын орчимд 2 удаа, 10 микроноос бага хэмжээтэй тоосны агууламж Хархорин захын орчимд 30 удаа, 13-р хороолол орчимд 25 удаа, Баруун дөрвөн замын орчимд 7 удаа, 32-ын тойрог орчимд 2 удаа агаарын чанарын стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс тус тус давсан байна.

# I. Нийгмийн үзүүлэлт

## I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 2012 оны 10 дугаар сарын эцэст 40.1 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 745 хүнээр буюу 1.9 хувиар өсчээ. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 52.8 хувийг эмэгтэйчүүд эзэлж өмнөх оны мөн үеийнхээс 0.2 пунктээр буурч 21.2 мянгад хүрэв. Аймаг, нийслэлийн хөдөлмөрийн хэлтэст 2012 оны эхний 10 сард ажилгүй 51.6 мян.иргэн шинээр бүртгүүлж, бүртгэлтэй байсан 26.8 мянган ажилгүй иргэн ажилд зуучлагдан орж, 8.0 мян.иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар бүртгэлээс хасагджээ (Зураг I.1).

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 0.5 хувийг магистр, доктор, 29.9 хувийг нь дипломын болон бакалаврын, 5.4 хувийг тусгай мэргэжлийн дунд, 7.6 хувийг техникийн болон мэргэжлийн, 37.5 хувийг бүрэн дунд, 13.8 хувийг суурь, 4.2 хувийг бага боловсролтой, 1.1 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна (Зураг I.2). Улсын хэмжээнд бүртгэлтэй ажилгүй иргэдийн 25.5 мянга буюу 63.6 хувь нь 15-34 насны залуучууд байгаа бөгөөд энэ үзүүлэлт Ховд, Дорнод, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Архангай, Орхон аймагт улсын дунджаас 2.0-16.9 пунктээр их байна.

## Ажлын шинэ байр

Хөдөлмөрийн яамны мэдээгээр 2012 оны эхний 10 сард 35387 хүн ажлын шинэ байранд ажилд орсны 15417 буюу 43.6 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажлын шинэ байранд ажилд орсон ажиллагчдыг эдийн засгийн үйл ажиллагааны салбараар ангилбал 2.0 хувийг төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгааллын, 2.8 хувийг боловсролын, 3.4 хувийг тээвэр ба агуулахын үйл ажиллагааны, 4.6 хувийг зочид буудал, байр сууц болон нийтийн хоолны үйлчилгээний, 7.4 хувийг үйлчилгээний бусад үйл ажиллагааны, 8.6 хувийг уул уурхай, олборлолтын, 11.9 хувийг бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний, 15.9 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 18.1 хувийг хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуурын болон барилгын салбар тус бүр, 7.2 хувийг бусад салбарын ажиллагчид эзэлж байна (Зураг I.3).

Зураг-I.1

**Хөдөлмөрийн хэлтэст шинээр бүртгүүлсэн болон ажилд зуучлагдан орсон иргэдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.2

**Бүртгэлтэй ажилгүй иргэд, боловсролын түвшнээр, 2012 оны 10 дугаар сарын эцэст**




Зураг-I.3

**Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, эдийн засгийн үйл ажиллагааны салбараар, 2012 оны эхний 10 сард**



Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 6880 буюу 19.4 хувь нь 15-24 насны, 12724 буюу 36.0 хувь нь 25-34, 8786 буюу 24.8 хувь нь 35-44, 6493 буюу 18.3 хувь нь 45-59, 504 буюу 1.5 хувь нь 60 ба түүнээс дээш насны хүмүүс байна.(Зураг I.4).

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэдийн 0.3 хувь нь зэвсэгт хүчний ажил мэргэжилтэй, 2.5 хувь нь контор, үйлчилгээний ажилтан, 3.4 хувь нь техникч болон туслах/дэд мэргэжилтэн, 3.8 хувь нь менежер, 5.7 хувь нь суурин төхөөрөмж, машин, механизмын операторч, угсрагч, 10.7 хувь нь мэргэжилтэн, 16.5 хувь нь худалдаа, үйлчилгээний ажилтан, 16.8 хувь нь энгийн ажил мэргэжил, 17.4 хувь нь хөдөө аж ахуй, ой, загас агнуурын ажилтан, 22.9 хувь нь үйлдвэрлэл, барилга, гар урлалын холбогдох ажил үйлчилгээний мэргэжилтэй хүмүүс байна.

**Дундаж цалин**

Ажиллагчдын дундаж цалингийн 2012 оны 3 дугаар улирлын мэдээнд нийслэлийн 195, аймаг, орон нутгийн 820, нийт 1015 аж ахуйн нэгж, байгууллагын 157.8 мянган ажиллагчид хамрагдсаны 80.6 мянга буюу 51.1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин 2012 оны 3 дугаар улиралд 565.5 мян. төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 142.3 мян. төг буюу 33.6 хувиар нэмэгджээ (Зураг I.5).

Эрэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин 2012 оны 3 дугаар улиралд 605.7 мян. төг болж, эмэгтэйчүүдийнхээс 78.8 мян.төг буюу 15.0 хувиар илүү байна (Зураг I.6).

Хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерээр ажиллаж байгаа эрэгтэйчүүдийн сарын дундаж цалин 983.0 мян.төг буюу хамгийн их байхад, энгийн ажил мэргэжлээр ажиллаж байгаа эрэгтэй ажиллагчдын цалин 423.9 мян.төг буюу хамгийн бага байна. Мөн хууль тогтоогч, төрийн ба төрийн бус байгууллагын удирдах ажилтан, менежерээр ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн сарын дундаж цалин 813.5 мян.төг буюу хамгийн их байхад, ХАА, загасны аж ахуйн мэргэшсэн эмэгтэй ажиллагчдын сарын дундаж цалин 191.4 мян. төг буюу хамгийн бага байна (Зураг I.6).

Эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт ажиллагчдын сарын дундаж цалин

Зураг-I.4

**Ажлын шинэ байранд ажилд орсон иргэд, насны бүлгээр, дүнд харьцуулсан хувиар, 2012 оны эхний 10 сард**




Зураг-I.5

**Ажиллагчдын сарын дундаж цалин, жил бүрийн 3 дугаар улирлын байдлаар, мян.төг**




Зураг-I.6

**Ажиллагчдын сарын дундаж цалин, хүйсээр, ажил мэргэжлийн ангиллаар, 2012 оны 3 дугаар улирлын байдлаар, мян.төг**



2012 оны 3 дугаар улиралд 579.7 мян.төг, барилгын салбарынх 583.1 мян.төг, төрийн удирдлага, батлан хамгаалах, нийгмийн даатгалын салбарынх 635.8 мян.төг, уул уурхайн олборлох үйлдвэрийн салбарынх 799.8 мян.төг, санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагааны салбарынх 1105.0 мян. төг болж, улсын дунджаас 14.2-539.5 мянган төгрөгөөр илүү, харин цахилгаан, хий, үйлдвэрлэл, усан хангамж, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн бусад үйл ажиллагаа, тээвэр, холбоо, агуулахын аж ахуй, боловсруулах аж үйлдвэрийн салбарынх 21.7-58.4 мян.төг, боловсрол, нийгэм, бие хүнд үзүүлэх үйлчилгээ, зочид буудал, зоогийн газар, бөөний болон жижиглэн худалдаа, гэр ахуйн засвар үйлчилгээ, хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуйн салбарынх 111.7-313.1 мянган төгрөгөөр бага байна.

Ажиллагчдын сарын дундаж цалинг аж ахуйн нэгж, байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзэхэд хязгаарлагдмал хариуцлагатай компани болон төрийн өмчит үйлдвэрийн газарт ажиллагчдын сарын дундаж цалин 2012 оны 3 дугаар улиралд улсын дунджаас 25.0-49.6 мянган төгрөгөөр илүү, харин төсөвт байгууллага, хувьцаат компанид ажиллагдынх 0.2-14.3 мян.төг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл болон зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөлд ажиллагчдынх 117.5-190.2 мян.төг, төрийн бус байгууллага, хоршоонд ажиллагчдын сарын дундаж цалин 228.5-298.0 мянган төгрөгөөр бага байна (Зураг I.7).

Зураг-I.7

**Ажиллагчдын сарын дундаж цалин, байгууллагын хариуцлагын хэлбэрээр, 2012 оны 3 дугаар улирлын байдлаар, мян.төг**




Төсөвт байгууллагад ажиллагчдын сарын дундаж цалин 2012 оны 3 дугаар улиралд 565.3 мянган төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 179.1 мянган төгрөг буюу 46.4 хувиар нэмэгджээ.

## I.2 Нийгмийн даатгал, халамж

### Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны эхний 10 сард 814.3 тэрбум төг, зарлага 749.2 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 225.5 тэрбум төг буюу 38.3 хувь, зарлага 257.9 тэрбум төг буюу 52.5 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2012 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 225.5 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 171.8 тэрбум төг буюу 41.3 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 13.4 тэрбум төг буюу 40.8 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 8.7 тэрбум төг буюу 39.7 хувь, ажилгүйдлийн даатгалын сангийн орлого 5.9 тэрбум төг буюу 28.4 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 25.6 тэрбум төг буюу 26.2 хувиар өссөн нь нөлөөлжээ.

Нийгмийн даатгалын сангийн зарлага 2012 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 257.9 тэрбум төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 216.3 тэрбум төг буюу 57.9 хувь, эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага 27.0 тэрбум төг буюу 39.3 хувь, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн зарлага 6.6 тэрбум төг буюу 38.3 хувь, тэтгэмжийн даатгалын сангийн зарлага 8.6 тэрбум төг буюу 34.7 хувиар өссөн нь нөлөөлөв. Харин ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага 631.2 сая төг буюу 9.3 хувиар буурсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн хэмжээ 2012 оны эхний 10 сард 576.3 тэрбум төг болсны 72.8 хувийг өндөр настны, 12.4 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 8.7 хувийг цэргийн, 6.1 хувийг тэжээгчээ алдсаны тэтгэвэр эзэлж байгаа нь

өмнөх оны мөн үеийнхээс цэргийн тэтгэвэр 99.2 хувь, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэтгэвэр 60.4 хувь, өндөр настны тэтгэвэр 54.1 хувь, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 49.1 хувиар өсчээ. ( Зураг I.8).

Нийгмийн даатгалд 2012 оны эхний 10 сард 687.0 мян.хүн шимтгэл төлөгч, даатгуулагчаар бүртгэгдсэний 464.6 мянга буюу 67.6 хувь нь аж ахуйн нэгж байгууллагынх, 222.4 мянга буюу 32.4 хувь нь төсөвт байгууллагынх байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийт шимтгэл төлөгч, даатгуулагчдын тоо 80.5 мянга буюу 13.3 хувь, үүнээс аж ахуйн нэгж, байгууллагынх 69.2 мянга буюу 17.5 хувь, төсөвт байгууллагынх 11.4 мянга буюу 5.4 хувиар нэмэгджээ.

## Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны эхний 10 сард 178.2 мян.хүнд 92.9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж олгосон бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авагчдын тоо 3.7 мян.хүн буюу 2.1 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 39.2 тэрбум төг буюу 73.0 хувиар өсчээ.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын 48.2 хувь нь жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүд, 34.0 хувь нь халамжийн тэтгэвэр авагчид, 8.4 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэд, 8.2 хувь нь ахмад настныг асарч буй иргэд, 1.2 хувь нь бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөж буй иргэд байна. (Зураг I.9).

Нийгмийн халамжийн сангаас 2012 оны эхний 10 сард олгосон нийт тэтгэвэр, тэтгэмжийн 54.9 тэрбум төг буюу 59.2 хувийг халамжийн тэтгэвэрт, 25.6 тэрбум төг буюу 27.6 хувийг жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдэд, 5.8 тэрбум төг буюу 6.2 хувийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэдэд, 5.6 тэрбум төг буюу 6.1 хувийг ахмад настныг асарч буй иргэдэд, 873.7 сая төг буюу 0.9 хувийг бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч өсгөсний тэтгэмжид зарцуулсан байна. (Зураг I.10).

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2012 оны эхний 10 сард 60.6 мян.хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 3.7 мян.хүн буюу 6.6 хувиар, олгосон тэтгэврийн хэмжээ 26.2 тэрбум төг буюу 91.0 хувиар нэмэгджээ.

Зураг-I.8

**Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэврийн бүтэц, төрлөөр, 2012 оны эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.9

**Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид хамрагдагчдын бүтэц, 2012 оны эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.10

**Нийгмийн халамжийн сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц, 2012 оны эхний 10 сарын байдлаар**



Нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтөд 351.5 мян.хүн хамрагдсаны 31.1 хувь нь ахмад настан, 1.3 хувь нь алдар цолтой ахмад настан, 4.0 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 59.0 хувь нь нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт мөнгөн тусламжид хамрагдсан иргэд, 4.6 хувь нь нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан иргэд байна.

Хүний хөгжил сангаас 2012 оны 10 дугаар сараас эхлэн 18 хүртэлх насны 744.5 мянган хүүхдэд 14.9 тэрбум төгрөгийн хүүхдийн мөнгө олгожээ. Хүний хөгжил сангаас олгож байсан 10.0, 21.0, 70.0 мян.төгрөгийн хишиг хувь болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгож байсан 1.0 сая төгрөгийн хишиг хувийн санхүүжилтийг 10 дугаар сараас зогсоосон байна.

## I.3 Эрүүл мэнд

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сард 62085 эх амаржиж, амьд төрсөн хүүхдийн тоо 62347 болж, өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 3418 эхээр буюу 5.8 хувь, хүүхдийн тоо 3450 хүүхдээр буюу 5.9 хувиар тус тус нэмэгдсэн байна. (Зураг I.11) Энэ оны 10 дугаар сард 6491 хүүхэд амьд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 51 хүүхэд буюу 0.8 хувиар нэмэгдлээ.

Улсын хэмжээгээр энэ оны эхний 10 сард нялхсын эндэгдэл 949 болж, өмнөх оны мөн үеийнхээс 16 хүүхэд буюу 1.7 хувь, 1-5 хүртэлх насандаа 206 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхэд буюу 2.4 хувиар буурав. (Зураг I.12). Энэ оны эхний 10 сард жирэмслэлт болон төрөлтийн улмаас 30 эх, 10 дугаар сард 3 эх эндсэн байна.

Нялхсын эндэгдэл 2012 оны 10 дугаар сард 105 болж, өмнөх оны мөн үеийнхээс 2 хүүхдээр, 1-5 хүртэлх насандаа 21 хүүхэд эндэж, өмнөх оны мөн үеийнхээс 3 хүүхдээр тус тус буурав.

1000 амьд төрөлтөд ногдох нялхсын эндэгдэл 2012 оны эхний 10 сард 15 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр буурсан бөгөөд энэ үзүүлэлт Хөвсгөл (24), Сүхбаатар (24), Завхан (23), Өвөрхангай (22), Баян-Өлгий (21), Булган (21) аймагт улсын дунджаас 6-9 хүүхдээр, Говь-Алтай (19), Архангай (19), Өмнөговь (19), Ховд (18), Дорноговь (17), Баянхонгор (16) аймагт 1-4 хүүхдээр илүү байна.

Зураг-I.11

**Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.12

**Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Тав хүртэлх насны* хүүхдийн эндэгдэл 2012 оны 10 дугаар сард 126 болж, өмнөх оны мөн үеийнхээс 5 хүүхдээр буурсан байна. 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл энэ оны эхний 10 сард 19 болж, өмнөх оны мөн үеийнхээс 1 хүүхдээр буурчээ.

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2012 оны эхний 10 сард вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 4390 хүн буюу 43.4 хувь, салхин цэцгээр 531 хүн буюу 20.2 хувь, цусан

*Тайлбар: *Тав хүртэлх насны хүүхдэд 0-4 нас 365 хүртэл хоногтой хүүхдийг хамруулав.*

суулгаар 59 хүн буюу 3.1 хувь, сүрьеэгээр 67 хүн буюу 1.9 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 45 хүн буюу 1.3 хувиар буурсан хэдий ч халдварт өвчнөөр өвчлөгчдийн нийт тоо 36073 болж, 2625 хүн буюу 7.8 хувиар нэмэгдсэн нь гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 7129 хүн буюу 9.3 дахин, тэмбүүгээр өвчлөгчдийн тоо 400 хүн буюу 11.3 хувиар өссөнөөс голлон шалтгаалав.

Халдварт өвчнөөр 2012 оны 10 дугаар сард 3672 хүн өвчилж, өмнөх оны мөн үеийнхээс 395 хүн буюу 9.7 хувиар буурахад вирүст хепатитаар өвчлөгчдийн тоо 1296 хүн буюу 65.4 хувь, трихомониазаар өвчлөгчдийн тоо 61 хүн буюу 16.3 хувиар буурсан нь нөлөөлөв. Харин энэ хугацаанд гахайн хавдраар өвчлөгчдийн тоо 203 хүн буюу 17.9 дахин, салхин цэцгээр 173 хүн буюу 4.6 дахин, цусан суулгаар 70 хүн буюу 50.0 хувь, тэмбүүгээр 140 хүн буюу 38.7 хувь, сүрьеэгээр өвчлөгчдийн тоо 31 хүн буюу 12.9 хувиар нэмэгдэв.

Энэ оны 10 дугаар сард хүнсний гаралтай бактерит хордлогын нийт 548 тохиолдол бүртгэгдсэнээс 546 нь Улаанбаатар хотод илэрсний дотор СБД-ийн Орчлон дунд сургуулийн сурагч ажилчид 335, ХУД-ийн 34-р сургуулийн сурагчид 201, БЗД, СБД болон БГД-т 10 тохиолдол тус тус илэрчээ.

10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо 2012 оны эхний 10 сард улсын дунджаар 131 болж, өмнөх оны мөн үеийнхээс 13 хүнээр нэмэгдэв (Зураг I.13).

Улаанбаатар хотод 2012 оны 10 дугаар сард ХДХВ/ДОХ-ын 2 тохиолдол илэрсэн ба улсын хэмжээнд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын нийт тохиолдол 115 байна.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сард 14268 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс 32 хүн буюу 0.2 хувиар буурав (Зураг I.14). Эмнэлэгт нас барсан хүний тоо энэ оны эхний 10 сард 3527 болж, өмнөх оны мөн үеийнхээс 15 хүн буюу 0.4 хувиар буурчээ. Энэ нь нийт нас баралтын 24.7 хувийг эзэлж байна. Нас барсан хүний тоо энэ оны 10 дугаар сард 1448 болж, өмнөх оны мөн үеийнхээс 9 хүн буюу 0.6 хувиар буурав.

Зураг-I.13

**10 000 хүн амд ногдох халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.14

**Нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Энэ оны эхний 10 сард 591.8 мян.хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 25357 хүн буюу 4.5 хувиар нэмэгджээ. Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн тоо 2012 оны 10 дугаар сард 61.0 мянга болж, өмнөх оны мөн үеийнхээс 2506 хүн буюу 4.3 хувиар нэмэгдэв.

Хувийн эмнэлгүүд 2012 оны эхний 10 сард 1157.5 мян.хүнд үйлчилж, 36.8 тэрбум төгрөгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлжээ. Хувийн эмнэлгээр үйлчлүүлсэн хүний тоо өмнөх оны мөн үеийнхээс 12.5 хувиар нэмэгдэж, төлбөрт үйлчилгээний хэмжээ 71.4 хувиар өслөө.

## I.4 Гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сарын байдлаар 18252 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2286 хэргээр буюу 14.3 хувиар өсчээ (Зураг I.15). Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо нэмэгдэхэд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг (1457), хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг (398), тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг (187), байгаль хамгаалах журмын эсрэг (147) зэрэг гэмт хэрэг өссөн нь голлон нөлөөлөв.

Энэ 2012 оны эхний 10 сард бүртгэгдсэн гэмт хэргийн 57.4 хувь нь нийслэлд, 41.6 хувь нь аймгуудад, 0.5 хувь нь төмөр замын цагдаагийн хэлтэст, 0.5 хувь нь бусад газарт бүртгэгджээ.

Бүртгэгдсэн гэмт хэргийн 45.7 хувийг хүндэвтэр, 43.0 хувийг хөнгөн, 8.9 хувийг хүнд, 2.4 хувийг онц хүнд гэмт хэрэг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс хөнгөн хэргийнх 2.1 пунктээр нэмэгдэж, хүндэвтэр хэргийнх 1.3 пункт, хүнд хэргийнх 0.5 пункт, онц хүнд хэргийнх 0.3 пунктээр буурсан байна (Зураг I.16).

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеийнхээс Баян-Өлгий аймагт 47.5 хувь, Завхан аймагт 37.6 хувь, Говьсүмбэр аймагт 35.1 хувь, Дорнод аймагт 34.4 хувь, Говь-Алтай аймагт 22.1 хувь, Төв аймагт 21.9 хувь, Булган аймагт 21.3 хувь, Өвөрхангай аймагт 20.4 хувь, Өмнөговь аймагт 15.8 хувь, Архангай аймагт 15.4 хувь, Сэлэнгэ аймагт 14.2 хувь, Сүхбаатар аймагт 11.3 хувь, Дархан-Уул аймагт 9.9 хувь, Дундговь аймагт 7.3 хувь, Дорноговь аймагт 6.2 хувь, Орхон аймагт 3.9 хувь, Улаанбаатар хотод 16.0 хувиар нэмэгдэж, харин Увс аймагт 8.8 хувь, Ховд аймагт 7.8 хувь, Хөвсгөл аймагт 7.2 хувь, Хэнтий аймагт 5.4 хувь, Баянхонгор аймагт 4.0 хувиар буурчээ.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 458 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 134 хэрэг буюу 41.4 хувиар нэмэгдсэн байна. Малын хулгайн 1126 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт гэмт хэргийн 6.2 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 277 хэрэг буюу 32.6 хувиар өсчээ.

Сэжигтэн нь тодорхойгүй байсан 6607 хэргийн 3834 буюу 58.0 хувийнх нь холбогдогч нь тогтоогдож, яллагдагчаар татагдсанаар гэмт хэргийн илрүүлэлт улсын хэмжээнд өмнөх оны мөн үеийнхээс 0.4 пунктээр нэмэгдэж, нийслэлийн хэмжээнд 3.3 пунктээр буурсан байна. (Зураг I.17).

Зураг-I.15

**Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Зураг-I.16

**Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэргийн ангиллаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**




Зураг-I.17

**Гэмт хэргийн илрүүлэлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**



Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2012 оны эхний 10 сарын байдлаар өмнөх оны мөн үеийнхээс 95.0 хувь, эмэгтэй хүн оролцсон хэрэг 87.0 хувь, бүлэглэн үйлдэгдсэн хэрэг 20.3 хувь, согтуугаар үйлдэгдсэн хэрэг 14.3 хувиар нэмэгдэв.

Арван найм ба түүнээс дээш насны 10000 хүнд ногдох гэмт хэргийн тоо улсын дунджаар 2012 оны эхний 10 сарын байдлаар 97 болж, өмнөх оны мөн үеийнхээс 10 хэрэг буюу 11.5 хувиар нэмэгдэв.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагч 2012 оны эхний 10 сарын байдлаар 16404 болж, 1082 буюу 6.6 хувь нь арван найм хүртэлх насны хүүхэд, 2218 буюу 13.5 хувь нь эмэгтэйчүүд байна. Өмнө нь ял шийтгэгдсэн хүмүүс гэмт хэрэгт холбогдогчдын 4.6 хувийг эзэлж байгаа бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс 0.9 пунктээр буурчээ.

Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдад хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн эзлэх хувь 2012 оны эхний 10 сарын байдлаар 11.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.4 пункт, малчдынх 9.4 болж 2.0 пункт, төрийн бус байгууллагын ажиллагчдынх 1.9 болж 0.1 пункт, оюутан, сурагчдынх 7.3 болж 0.7 пунктээр нэмэгдэж, харин ажилгүй иргэдийнх 52.7 болж 5.1 пункт, аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагчдынх 11.2 болж 0.9 пункт, төрийн албан хаагчдынх 4.3 болж 0.7 пунктээр буурсан байна.

Энэ оны эхний 10 сарын байдлаар бүртгэгдсэн гэмт хэргийн 29.4 хувь нь гэр, орон сууцанд, 16.4 хувь нь гудамж, талбайд, 13.1 хувь нь олон нийтийн газарт, 7.8 хувь нь аж ахуйн нэгжид, 8.7 хувь нь авто замд, 2.2 хувь нь төрийн байгууллагад, 1.3 хувь нь төрийн бус байгууллагад, 1.3 хувь нь нийтийн тээврийн хэрэгсэлд, 19.8 хувь нь бусад газарт үйлдэгджээ.

Гэмт хэргийн улмаас 6947 хүн гэмтэж, 800 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 366 буюу 5.6 хувиар өсч, нас барсан хүний тоо 88 буюу 9.9 хувиар буурсан байна (Зураг I.19).

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2012 оны эхний 10 сарын байдлаар 38.2 тэрбум төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 20.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 15385.4 сая төг буюу 67.3 хувиар, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 11596.1 сая төг буюу 2.3 дахин өссөн байна (Зураг I.20).

Зураг-I.18

**Гэмт хэрэгт холбогдсон сэжигтэн, яллагдагчдын нийгмийн байдал, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**




Зураг-II.19

**Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**




Зураг-II.20

**Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, тэрбум төгрөгөөр**



Нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ нэмэгдэхэд хувийн өмчийн байгууллагад учирсан хохирлын нөхөн төлүүлэлт 8626.8 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлөв. Гэмт хэргийн улмаас учирсан нийт хохирлын 86.6 хувь буюу 33.1 тэрбум төг нь хувийн өмчид ногдож байна.

Гэмт хэргийн улмаас хохирсон иргэд 2012 оны эхний 10 сарын байдлаар 17506 болж, 1081 буюу 6.2 хувь нь арван найм хүртэлх насны хүүхэд, 6551 буюу 37.4 хувь нь эмэгтэйчүүд байна.

Гэмт хэргийн улмаас нийт 127 байгууллагад хохирол учирсны 60 нь төрийн, 21 нь төрийн бус, 46 нь хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага байна.

Улсын хэмжээнд 2012 оны эхний 10 сарын байдлаар 98.1 мян.хүн эрүүлжүүлэгдэж, 11.9 мян.хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 1540 буюу 1.6 хувь, баривчлагдсан хүний тоо 1456 буюу 13.9 хувиар өссөн байна.

## II. Макро эдийн засгийн үзүүлэлт

### II.1. Үнэ

#### Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ

Хэрэглээний үнийн улсын индекс (ХҮУИ) 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувь, оны эхнээс 12.9 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.0 хувиар өслөө (Хүснэгт II.1).

Ерөнхий индекс өмнөх сарынхаас өсөхөд орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 4.6 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийнх 2.1 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.9 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 1.7 хувь, тээврийнх 0.8 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.5 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 0.4 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 0.8 хувиар өсч, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ болон боловсролын үйлчилгээний бүлгийн дүн тогтвортой харин хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.2 хувиар буурсан байна.

Хүснэгт-II.1

**Хэрэглээний үнийн улсын индекс, бүлгийн дүнгээр**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Жин | 2012 X / 2011 X | 2012 X / 2011 XII | 2012 X / 2012 IX |
|---|---|---|---|---|
| **Ерөнхий индекс** | **100.0** | **115.0** | **112.9** | **100.6** |
| Хүнсний бараа, ундаа, ус | 29.3 | 119.8 | 115.6 | 97.8 |
| Согтууруулах ундаа, тамхи | 3.2 | 153.3 | 152.5 | 103.3 |
| Хувцас, бөс бараа, гутал | 16.1 | 117.1 | 113.4 | 102.1 |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 12.3 | 113.6 | 112.2 | 104.6 |
| Гэр ахуйн тавилга, бараа | 4.7 | 109.7 | 108.8 | 100.9 |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 3.6 | 108.9 | 108.7 | 101.7 |
| Тээвэр | 12.2 | 106.0 | 105.5 | 100.8 |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ | 4.4 | 98.5 | 98.6 | 100.0 |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 2.8 | 102.5 | 102.8 | 100.5 |
| Боловсролын үйлчилгээ | 4.7 | 115.2 | 115.2 | 100.0 |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ | 2.6 | 123.8 | 122.3 | 100.4 |
| Бусад бараа, үйлчилгээ | 4.1 | 107.8 | 106.9 | 100.8 |

Хэрэглээний үнийн улсын индекс 2012 оны 10 дугаар сард оны эхнээс 12.9 хувь өссөний дотор хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнэ дунгээрээ 15.6 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийнх 52.5 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 13.4 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 12.2 хувь,боловсролын үйлчилгээний бүлгийнх 15.2 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээнийх 22.3 хувиар нэмэгдсэн нь өндөр өсөлт байв.

Хэрэглээний үнийн улсын индекс 2011 оны 10 дугаар сард оны эхнээс 6.7 хувиар өссөн бол 2012 оны 10 дугаар сард 12.9 хувь болж, өсөлт 6.2 пунктээр нэмэгджээ (Зураг II.1).

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас Сэлэнгэ, Булган, Дархан-Уул, Ховд аймагт 0.2-0.8 хувиар буурч, бусад аймаг, нийслэлд 0.2-3.4 хувиар өсчээ (Зураг II.2).

Өрхийн нийт хэрэглээнд өндөр хувийн жин эзэлж буй мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дунгээрээ 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас Говьсүмбэр (0.3%), Орхон (2.1% ), Булган (4.2%) аймагт өсч, Архангай аймагт тогтвортой, бусад 17 аймагт 0.1-11.8 хувиар буурчээ. Өмнөговь (11.8%) аймагт хамгийн их бууралттай байв.

Талх, гурил, будааны дэд бүлгийн үнэ дунгээрээ Сүхбаатар (0.1%), Ховд (0.1%), Завхан (1.3%) аймагт буурч, Булган, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий, Дархан-Уул аймагт тогтвортой, бусад 11 аймагт 0.1-4.2 хувиар өссөн байна. Архангай (4.2%) аймагт хамгийн өндөр өсөлттэй байлаа.

Сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ дунгээрээ Өмнөговь, Говьсүмбэр аймагт тогтвортой, бусад 19 аймагт 0.3-16.6 хувиар өссөн байна. Хөвсгөл (16.6%) аймагт хамгийн их өсөлттэй байв.

Төмс, хүнсний ногооны дэд бүлгийн үнэ дунгээрээ Дундговь (1.1%), Дархан-Уул (1.1%), Завхан (1.9%), Сэлэнгэ (4.6%), Баянхонгор (9.6%) аймагт өсч, Өвөрхангай, Орхон аймагт тогтвортой, бусад 14 аймагт 0.3-21.8 хувиар буурчээ. Булган (21.8%) аймагт хамгийн их бууралттай байлаа.

Зураг-II.1

**Хэрэглээний үнийн улсын индекс (өмнөх оны 12 сар =100)**




Зураг-II.2

**Хэрэглээний үнийн индекс, нийслэл, аймгаар, 2012 оны 10 дугаар сард (өмнөх сар =100%)**




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас Баянхонгор аймагт хамгийн их буюу 3.4 хувиар өсчээ. Тус аймагт үнэ өсөхөд хүнсний бүлгийн барааны үнэ дунгээрээ 3.5 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 5.6 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 7.0 хувь, гэр ахуйн тавилга, барааных 3.4 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Ховд аймагт хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Үнийн бууралтад хүнсний бүлгийн барааны үнэ дунгээрээ 4.7 хувь, үүний дотор мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 10.6 хувь, жимс, жимсгэнийх 1.4 хувь, хүнсний ногооных 5.8 хувиар хямдарсан нь нөлөөлжээ.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 10 дугаар сард оны эхнээс бүх аймагт 5.8-22.0 хувиар өссөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2012 оны 10 дугаар сард Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 0.2 хувь, оны эхнээс 13.7 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 15.0 хувиар өслөө.

2012 оны 10 дугаар сард согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дунгээрээ 1.8 хувь, хувцас, бөс бараа, гутлынх 1.8 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшнийх 4.3 хувь, гэр ахуйн тавилга, барааных 0.3 хувь, эм, тариа, эмнэлгийн үйлчилгээнийх 1.1 хувь, тээврийн бүлгийнх 1.6 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээнийх 0.8 хувь, бусад бараа, үйлчилгээнийх 1.3 хувиар өсчээ. Харин хүнс, ундаа, усны бүлгийн үнэ дунгээрээ 3.0 хувиар буурч, эдгээрээс бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнэ тогтвортой байв (Зураг II.3).

Улаанбаатар хотод 10 дугаар сард өмнөх сарынхаас хэрэглээний сагсны 329 нэрийн бараа, үйлчилгээний 24.0 хувийнх нь үнэ өсч, 10.0 хувийнх нь үнэ буурч, 66.0 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Судалгаанд сонгогдсон хүнсний 93 нэрийн барааны 34.4 хувь буюу 32 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг-II.3

**Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2012 оны 10 дугаар сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт**



Хүснэгт-II.2

**Улаанбаатар хотын хэрэглээний үнийн 2012 оны 10 дугаар сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт**

| Бараа, үйлчилгээний бүлэг | Үнийн өөрчлөлт, % | Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт |
|---|---|---|
| Хүнсний бараа, ундаа, ус | -3.0 | Хүнс, ундаа, усны бүлгийн барааны үнийн бууралтад мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 6.8 хувь, төмс, хүнсний ногооных 7.2 хувиар хямдарсан нь нөлөөлжээ. |
| Согтууруулах ундаа, тамхи | 1.8 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд импортын цагаан архины үнэ 23.1 хувь, дарсны 1.0 хувь, шар айрагных 5.7 хувь, тамхины дэд бүлгийн үнэ 0.3 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв. |
| Хувцас, бөс бараа, гутал | 1.8 | Хувцас, бөс бараа, гутлын бүлгийн барааны үнийн өсөлтөд бүх төрлийн хувцасны дэд бүлгийн үнэ 2.4 хувь, хөвөн бөс, барааных 1.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш | 4.3 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд орон сууц түрээслэх хөлс 3.9 хувь, нэг уут түлшний модны үнэ 10.3 хувь, нүүрснийх 17.8 хувиар өссөн нь нөлөөлжээ. |
| Гэр ахуйн тавилга, бараа | 0.3 | Гэр ахуйн тавилга, барааны бүлгийн үнийн өсөлтөд эдийн савангийн үнэ 2.2 хувь, угаалгын нунтгийн үнэ 1.7 хувь, аяга, таваг угаагч бодисынх 4.7 хувь, гутлын тосных 2.9 хувиар өссөн нь нөлөөлөв. |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ | 1.1 | Энэ бүлгийн үнийн өсөлтөд хувийн эмнэлгийн ор хоногийн хөлс 4.5 хувиар өссөн нь нөлөөлжээ. |
| Тээвэр | 1.6 | Тээврийн бүлгийн үнийн өсөлтөд судалгаанд сонгогдсон суудлын тэрэгний үнэ 5.9 хувиар өссөн нь нөлөөлсөн байна. |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 0.8 | Энэ бүлгийн үнэ өсөхөд сурагчийн дэвтрийн үнэ 5.9 хувь, үзгэн балны запасны үнэ 31.7 хувиар өссөн нь нөлөөллөө. |
| Бусад бараа, үйлчилгээ | 1.3 | Бусад бараа, үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөд эмэгтэй хүний үс засах тариф 4.7 хувь, нийтийн халуун усанд орох хөлс 2.8 хувь, гар нүүрийн савангийн үнэ 3.3 хувь, бугуйн цагны үнэ 30.6 хувь, мөнгөн аяганы үнэ 40.0 хувиар өссөн нь нөлөөлжээ. |

## Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ

Мал аж ахуйн гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний зах зээлийн үнийн судалгаагаар 2012 оны 10 дугаар сард үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Увс, Ховд, Баянхонгор, Дундговь, Дорнод аймагт хамгийн бага буюу 20.0-25.0 мян.төг, Булган, Завхан, Архангай, Төв, Орхон аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 35.0-40.0 мян.төг, адууны ширнийх Увс, Сэлэнгэ, Ховд, Дархан-Уул аймагт хамгийн бага буюу 25.0-28.0 мян.төг, Архангай, Баянхонгор, Өвөрхангай, Хөвсгөл, Говьсүмбэр, Дундговь, Сүхбаатар, Хэнтий, Баян-Өлгий, Орхон, Төв аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 35.0-40.0 мян.төг, ямааны 1 кг цагаан ноолуурын үнэ Баян-Өлгий, Сүхбаатар, Завхан, Увс, Ховд, Дорноговь, Өмнөговь аймагт хамгийн бага буюу 35.0-40.0 мян.төг, Говь-Алтай,

Зураг-II.4

**Ямааны 1 кг цагаан ноолуурын зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 10 дугаар сард, мян.төг**



Зураг-II.5

**Адууны 1 ширхэг ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 10 дугаар сард, мян.төг**




Баянхонгор, Орхон, Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотод хамгийн их буюу 42.0-45.0 мян.төг байна.

Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний дундаж үнэ Дархан-Уул, Говьсүмбэр, Төв, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл, Сүхбаатар, Завхан, Булган аймагт өмнөх сарынхаас 1.0-10.0 мян.төг буюу 3.3-40.0 хувиар өсч, Ховд, Дорнод, Увс, Баянхонгор аймагт 1.0-5.0 мян.төг буюу 4.5-20.0 хувиар буурч, Архангай, Дундговь, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарын түвшинд байв.

Адууны 1 ширхэг ширний дундаж үнэ Завхан, Өвөрхангай, Дундговь, Сүхбаатар, Баянхонгор, Төв, Ховд, Орхон, Увс, Баян-Өлгий, Булган, Өмнөговь, Говьсүмбэр, Хөвсгөл аймаг, Улаанбаатар хотод өмнөх сарынхаас 2.0-10.0 мян.төг буюу 5.3-40.0 хувиар өсч, Сэлэнгэ, Архангай аймагт өмнөх сарынхаас 2.5-3.0 мян.төг буюу 7.9-9.1 хувиар буурч, Дархан-Уул, Дорнод, Хэнтий аймагт өмнөх сарын түвшинд байв.

## Улаанбаатар хотод арилжаалагдсан барилгын гол нэрийн материалын дундаж үнэ

Улаанбаатар хотод 2012 оны 10 дугаар сард арилжаалагдсан эх орны үйлдвэрийн болон ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ-д үйлдвэрлэсэн барилгын үндсэн 29 нэр төрлийн материалын дундаж үнийг мэдээнд хамрууллаа.

Зураг-II.6

**Үхрийн 2 м-ээс дээш урттай ширний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 10 дугаар сард, мян.төг**




Зураг-II.7

**Хонины ноостой нэхийний зах зээлийн дундаж үнэ, жил бүрийн 10 дугаар сард, мян.төг**




Ямааны 1 кг цагаан ноолуурын дундаж үнэ Баянхонгор, Хөвсгөл аймагт өмнөх сарынхаас 1.0-2.0 мян.төг буюу 2.3-4.7 хувиар өсч, Дундговь, Увс, Архангай, Говь-Алтай, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотод 0.5-5.0 мян.төг буюу 1.2-11.8 хувиар буурч, Баян-Өлгий, Завхан, Орхон, Дархан-Уул, Дорноговь, Өмнөговь аймагт өмнөх сарын түвшинд байв.

Өмнөх оны мөн үеийнхээс БНХАУ-д үйлдвэрлэсэн цонхны нөлөөгүй шилний үнэ 2.0 мян.төг буюу 13.3 хувь, 50 кг-ын савлагаатай цементний үнэ 1.0 мян.төг буюу 9.1 хувь, эх орны үйлдвэрийн захалсан банзны үнэ 3.0 мян.төг буюу 7.9 хувиар буурчээ. Эх орны үйлдвэрийн улаан тоосгоны нэг ширхэгийн үнэ 88 төг буюу 46.3 хувь, хөнгөн

бетоных 35.7 мян.төг буюу 31.0 хувь, шалны ховилгүй банзных 20.0 мян.төг буюу 13.3 хувь, вакуум цонхных 10.0 мян.төг буюу 12.5 хувь, палкных 3.0 мян.төг буюу 12.0 хувь, БНХАУ-д үйлдвэрлэсэн уян шүршүүрийн үнэ 7.0 мян. төг буюу 38.9 хувь, шаазан угаагуурынх 20.0 мян.төг буюу 33.3 хувь, тосон будагных 500 төг буюу 25.0 хувь, өдрийн суурьгүй гэрлийнх 400 төг буюу 20.0 хувь, шахмал шалных 2.0 мян. төг буюу 16.7 хувь, төмөр хаалганых 22.0 мян. төг буюу 15.9 хувь, шаазан суултуурынх 10.0 мян.төг буюу 11.1 хувь, крантных 5.0 мян.төг буюу 11.1 хувь, хадаасных 200 төг буюу 8.0 хувь, дотор эмульснийх 500 төг буюу 7.7 хувь, чулуугүй хар цаасных 500 төг буюу 5.6 хувиар өсчээ.

Өмнөх сарынхаас 2012 оны 10 дугаар сард эх орны үйлдвэрийн хуурай палкны үнэ 1.0 мян.төг буюу 3.4 хувь, хөнгөн бетоных 2.8 мян.төг буюу 1.8 хувь, ОХУ-д үйлдвэрлэсэн чулуутай хар цаасны үнэ 2.0 мян.төг буюу 9.1 хувь, БНСУ-д үйлдвэрлэсэн ханын цаасны үнэ 500 төг буюу 9.1 хувиар буурч, эх орны үйлдвэрийн шалны ховилгүй банзны үнэ 20.0 мян.төг буюу 13.3 хувь, улаан тоосгоны нэг ширхэгийн үнэ 3.0 төг 1.1 хувиар өсчээ.

## II.2 Мөнгө, зээл, үнэт цаас

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2012 оны 10 дугаар сарын эцэст 7132.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 20.4 тэрбум төг буюу 0.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 1054.3 тэрбум төг буюу 17.3 хувиар өсчээ (Хүснэгт II.1).

Мөнгөний нийлүүлэлтийн бүтцийн хувьд 2012 оны 10 дугаар сарын эцэст 44.5 хувийг төгрөгийн хадгаламж, 20.9 хувийг гадаад валютын хадгаламж, 15.1 хувийг төгрөгийн харилцах, 12.5 хувийг гадаад валютын харилцах, 7.0 хувийг банкнаас гадуурх мөнгө эзэлж байна (Зураг II.8). Мөнгөний нийлүүлэлтэд төгрөгийн хадгаламжийн эзлэх хувь өмнөх сарынхаас 1.2 пункт, гадаад валютын харилцахынх 0.2 пунктээр өсч, харин банкнаас гадуурх мөнгөнийх 0.7 пункт, төгрөгийн харилцахынх 0.4 пункт, гадаад валютын хадгаламжийнх 0.2 пунктээр буурчээ.

Бага мөнгө 2012 оны 10 дугаар сарын эцэст 1578.7 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 79.3 тэрбум төг буюу 4.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 44.2 тэрбум төг буюу 2.7 хувиар буурчээ.

Иргэд, байгууллагын нийт хадгаламж 2012 оны 10 дугаар сарын эцэст 4662.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 83.8 тэрбум төг буюу 1.8 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 917.4. тэрбум төг буюу 24.5 хувиар өсчээ. Төгрөгийн хадгаламж 2012 оны 10 дугаар сарын эцэст 3175.0 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 92.7 тэрбум төг буюу 3.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 331.3 тэрбум төг буюу 11.7 хувиар өсөв. Гадаад валютын хадгаламж 2012 оны 10 дугаар сарын эцэст 1487.3 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 8.9 тэрбум төг буюу 0.6 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 586.1 тэрбум төг буюу 65.0 хувиар өслөө (Хүснэгт II.3).

Зураг-II.8

**Мөнгөний нийлүүлэлт (M2), хэрэглээний үнийн улсын индексийн өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх сар=100)**




Хүснэгт-II.3

**Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, сарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 X | 2012 IX | 2012 X |
|---|---|---|---|
| **Мөнгөний нийлүүлэлт M2** | **6 078.3** | **7 112.2** | **7 132.6** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 56.9 | 17.5 | 17.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 0.4 | 1.6 | 0.3 |
| **Нийт хадгаламж** | **3 744.9** | **4 578.5** | **4 662.3** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 62.5 | 24.7 | 24.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.0 | 3.7 | 1.8 |
| **Төгрөгийн хадгаламж** | **2 843.7** | **3 082.3** | **3 175.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 71.7 | 10.9 | 11.7 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.3 | 0.0 | 3.0 |
| **Валютын хадгаламж** | **901.2** | **1 496.2** | **1 487.3** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 39.1 | 67.5 | 65.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 0.9 | 12.1 | - 0.6 |

Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө 2012 оны 10 дугаар сарын эцэст 717.6 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 28.0 тэрбум төг буюу 3.8 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 22.7 тэрбум төг буюу 3.3 хувиар өсчээ.

Нөөц мөнгө (М0) 2012 оны 10 дугаар сарын эцэст 2148.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 256.1 тэрбум төг буюу 10.7 хувиар буурлаа. Нөөц мөнгөний бүрэлдэхүүн хэсэг болох банкуудын харилцах, хадгаламж 2012 оны 10 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 228.0 тэрбум төг буюу 13.7 хувиар буурч, 1433.1 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Банкуудын нийт актив 2012 оны 10 дугаар сарын эцэст 9991.1 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 60.4 тэрбум төг буюу 0.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2283.3 тэрбум төг буюу 29.6 хувиар өслөө.

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон нийт зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 10 дугаар сарын эцэст 6855.4 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 11.9 тэрбум төг буюу 0.2 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1633.5 тэрбум төг буюу 31.3 хувиар өсчээ (Хүснэгт II.4).

Зээлийн өрийн үлдэгдлийг эзэмшигчээр нь авч үзэхэд 2012 оны 10 дугаар сарын эцэст нийт зээлийн 3740.6 тэрбум төг буюу 54.6 хувь нь хувийн секторт, иргэдэд 3064.7 тэрбум төг буюу 44.7 хувь нь, улсын байгууллагад 29.2 тэрбум төг буюу 0.4 хувь нь, бусад байгууллагад 10.7 тэрбум төг буюу 0.2 хувь нь, 10.2 тэрбум төг буюу 0.1 хувь нь бусад санхүүгийн байгууллагад ногдож байна.

Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээл 2012 оны 10 дугаар сарын эцэст 306.2 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 0.1 тэрбум төг буюу 0.03 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 41.3 тэрбум төг буюу 11.9 хувиар буурсан байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.5 хувийг эзэлж, өмнөх сарынхаас өөрчлөлтгүй, өмнөх оны мөн үеийнхээс 2.2 пунктээр буурчээ (Хүснэгт II.4).

Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2012 оны 10 дугаар сарын эцэст 132.5 тэрбум төг болж, өмнөх сарынхаас 15.5 тэрбум төг буюу 13.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 61.5 тэрбум төг буюу 86.6 хувиар өсчээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн

*Эх үүсвэр:* Монголбанкны статистикийн сарын бюллетень*

Зураг-II.9

**Мөнгөний нийлүүлэлтийн бүтэц, хувиар, жил бүрийн 10 дугаар сарын эцсийн байдлаар**




Зураг-II.10

**Мөнгөний нийлүүлэлт (М2), бага мөнгө (М1) болон бараг мөнгөний өөрчлөлт, сарын эцэст, хувиар, (өмнөх оны мөн үе=100)**




Хүснэгт-II.4

**Зээлийн өрийн үлдэгдэл, чанаргүй болон хугацаа хэтэрсэн зээл сарын эцэст, тэрбум төг**

| Үзүүлэлт | 2011 X | 2012 IX | 2012 X |
|---|---|---|---|
| **Зээлийн өрийн үлдэгдэл** | **5 221.9** | **6 867.3** | **6 855.4** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 69.0 | 35.7 | 31.3 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 3.2 | 2.9 | - 0.2 |
| **Чанаргүй зээл** | **347.5** | **306.3** | **306.2** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 13.6 | - 14.3 | - 11.9 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | - 2.7 | - 1.9 | 0.0 |
| **Хугацаа хэтэрсэн зээл** | **71.0** | **117.0** | **132.5** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 9.7 | 93.5 | 86.6 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 17.4 | 16.3 | 13.2 |
| **Зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь** | **6.7** | **4.5** | **4.5** |
| **Зээлийн өрийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь** | **1.4** | **1.7** | **1.9** |

үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 1.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх сарынхаас 0.2 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 0.5 пунктээр өссөн байна (Хүснэгт II.4).

Энэ оны 10 дугаар сарын эцэст аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зээлийн өрийн үлдэгдлийн 68.0 хувь нь ХААН банк, Голомт банк, Худалдаа, хөгжлийн банканд ногдож байна.

Банкуудын төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 оны 9 дүгээр сарын эцэст өмнөх сарынхаас 0.3 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 2.5 пунктээр өсч, жилийн хүү 18.6 хувь болжээ. Валютын зээлийн жигнэсэн дундаж хүү өмнөх сарынхаас 0.1 пункт, өмнөх оны мөн үеийнхээс 2.1 пунктээр өсч, жилийн хүү 14.2 хувь боллоо (Зураг II.12).

Гадаад валютын цэвэр албан нөөц 2012 оны 10 дугаар сарын эцэст өмнөх сарынхаас 290.7 сая ам.доллар, өмнөх оны мөн үеийнхээс 210.9 сая ам.доллараар нэмэгдэж, 2227.3 сая ам.долл болсон нь манай улсын импортын 16.9 долоо хоног буюу 4.2 сарын хэрэгцээг хангахаар байна (Зураг II.13).

### Үнэт цаасны зах зээл

Үнэт цаасны арилжаа 2012 оны 10 дугаар сард 23 өдөр явагдаж, 665.3 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 2.1 сая ш үнэт цаас арилжигдсан байна. Гүйлгээний хэмжээ 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 29.5 тэрбум төг буюу 45.4 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 50.5 тэрбум төг буюу 76.9 дахин буурчээ. Арилжсан үнэт цаасны тоо 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 10.0 сая ш буюу 5.8 дахин, өмнөх оны мөн үеийнхээс 5.8 сая ш буюу 3.8 дахин буурлаа.

Хөрөнгийн зар зээлийн чиг хандлагыг илэрхийлэх ТОП-20 дундаж индекс 2012 оны 10 дугаар сард 16840.7 болж, өмнөх сарынхаас 1046.4 нэгжээр буурчээ (зураг II.11). Хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа хувьцаат компаниудын үнэт цаасны зах зээлийн нийт үнэлгээ 2012 оны 10 дугаар сард 1660.6 тэрбум төгрөг болж, өмнөх сарынхаас 110.9 тэрбум төгрөг буюу 6.3 хувиар буурлаа (Зураг II.15).

"Э-ТРАНС ЛОЖИСТИКС" хувьцаат компаний 481.0 мянган ш хувьцаа 2012 оны 10 дугаар сард арилжигдсан нь хамгийн идэвхитэй арилжаалсан үнэт цаас байв.

Зураг-II.11

**Чанаргүй зээл, сарын эцэст, тэрбум төг**




Зураг-II.12

**Зээлийн жилийн хүү, сарын эцэст, хувиар**




Зураг-II.13

**Гадаад валютын цэвэр албан нөөц, сарын эцэст, сая ам.долл**




Зураг-II.14

**ТОП-20 индекс, сарын дундаж, хувиар**



## Валютын ханш

Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 10 дугаар сард 1387.0 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 95.1 төг буюу 7.4 хувиар суларсан байна (Хүснэгт II.3). Төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 2.2 хувиар суларч, 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.6 хувиар чангарчээ (Зураг II.16).

Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 10 дугаар сард 1798.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 27.2 төг буюу 1.5 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 6.0 хувь, 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар суларсан байна (Зураг II.17).

Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 10 дугаар сард 221.4 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 18.6 төг буюу 9.2 хувиар суларчээ (Хүснэгт II.3). Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 2.9 хувь, 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар суларчээ (Зураг II.18).

Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 10 дугаар сард 44.6 төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 3.3 төг буюу 8.0 хувиар суларчээ (Хүснэгт II.5). Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн дундаж ханш 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 3.7 хувь, 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.7 хувиар суларлаа (Зураг II.19).

Хүснэгт-II.5

**Монголбанкны төгрөгийн гадаад валюттай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**

| Үзүүлэлт | 2011 X | 2012 IX | 2012 X |
|---|---|---|---|
| **Ам. Доллар** | **1 291.9** | **1 394.8** | **1 387.0** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 1.1 | 10.7 | 7.4 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.5 | 2.2 | - 0.6 |
| **Евро** | **1 771.2** | **1 793.1** | **1 798.4** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 2.3 | 3.3 | 1.5 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.0 | 6.0 | 0.3 |
| **Юань** | **202.8** | **220.7** | **221.4** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | 3.6 | 11.9 | 9.2 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 2.9 | 2.9 | 0.3 |
| **Рубль** | **41.3** | **44.3** | **44.6** |
| Жилийн өөрчлөлт, хувиар, өмнөх оны мөн үе=100 | - 4.2 | 7.8 | 8.0 |
| Сарын өөрчлөлт, хувиар, өмнөх сар=100 | 0.6 | 3.7 | 0.7 |

Зураг-II.15

**Зах зээлийн үнэлгээ, сарын эцэст, тэрбум төг**




Зураг-II.16

**Төгрөгийн ам. доллартай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.17

**Төгрөгийн евротой харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.18

**Төгрөгийн юаньтай харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**




Зураг-II.19

**Төгрөгийн рубльтэй харьцах нэрлэсэн ханш, сарын дундаж, төг**



## II.3 Улсын нэгдсэн төсөв

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны эхний 10 сард 3942.5 тэрбум төг, зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4521.5 тэрбум төг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 579.0 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үеийнхээс улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал 703 тэрбум төгрөгөөр нэмэгдэхэд зарлагын өсөлт орлогын өсөлтөөс 22.0 пунктээр илүү байгаа нь нөлөөлжээ(Зураг II.20).

Улсын нэгдсэн төсвийн урсгал орлого 2012 оны эхний 10 сард 3904.8 тэрбум төг, урсгал зардал 3423.1 тэрбум төг болж тэнцвэржүүлсэн урсгал тэнцэл 481.7 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Өмнөх оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн урсгал орлого 510.5 тэрбум төг, урсгал зардал 938.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн нийт хэмжээ 2012 оны 9 дүгээр сард 386.3 тэрбум төг байсан бол 10 дугаар сард 456.7 тэрбум төг болж өмнөх сарынхаас 70.6 тэрбум төг буюу 18.2 хувиар өсчээ. Улсын нэгдсэн төсвийн нийт зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны 9 дүгээр сард 461.1 тэрбум төг байсан бол 10 дугаар сард 477.8 тэрбум төг болж 16.7 тэрбум төг буюу 3.6 хувиар өссөн байна. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2012 оны 9 дүгээр сард 74.8 тэрбум төг, 10 дугаар сард 21.1 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Зураг-II.20

**Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төг**




### Төсвийн орлого

Улсын нэгдсэн төсөвт 2012 оны эхний 10 сард 3968.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс 493.7 тэрбум төг буюу 14.2 хувиар өссөн байна.

Татварын нийт орлого өмнөх оны мөн үеийнхээс 466.9 тэрбум төг буюу 15.4 хувиар нэмэгдэхэд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 166.5 тэрбум төг буюу 45.5 хувь, дотоодын бараа, үйлчилгээний татварын орлого 160.0 тэрбум төг буюу 13.7 хувь, бусад татварын орлого 92.0 тэрбум төг буюу 17.1 хувь, орлогын албан татварын орлого 42.1 тэрбум төг буюу 6.3 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Татварын бус орлого өмнөх оны мөн үеийнхээс 43.6 тэрбум төг буюу 12.0 хувиар өсөхөд хувьцааны ногдол ашгийн орлого 2.9 тэрбум төг буюу 7.1 хувиар буурсан хэдий ч газрын тосны орлого 20.2 тэрбум төг буюу 41.9 хувь, хүү, торгуулийн орлого 12.2 тэрбум төг буюу 34.2 хувь, бусад нэр заагдаагүй орлого 10.0 тэрбум төг буюу 26.9 хувь, навигацын орлого 2.1 тэрбум төг буюу 6.0 хувь, төсөвт газрын өөрийн орлого 1.2 тэрбум төг буюу 0.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Улсын нэгдсэн төсвийн орлогын 88.2 хувийг татварын орлого, 10.2 хувийг татварын бус орлого, тогтворжуулалтын сангийн орлого болон тусламжийн орлого тус бүр 0.6 хувь, 0.3 хувийг хөрөнгийн орлого эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс тогтворжуулалтын сангийн орлогын эзлэх хувь 1.2 пункт, татварын бус орлогынх 0.2 пунктээр буурч, татварын орлогынх 0.9 пункт, тусламжийн орлогынх 0.5 пунктээр өсчээ (Хавсралт 5).

### Төсвийн зарлага

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 2012 оны эхний 10 сард 4521.5 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1236.9 тэрбум төг буюу 37.7 хувиар нэмэгдсэн нь эргэж төлөгдөх цэвэр зээл 206.5 тэрбум төг буюу 83.4 хувиар буурсан хэдий ч хөрөнгийн зардал 505.2 тэрбум төг буюу 91.5 хувь, бараа, үйлчилгээний зардал 475.4 тэрбум төг буюу 43.0 хувь, татаас ба шилжүүлгийн зардал 398.9 тэрбум төг буюу 29.6 хувь, зээлийн үйлчилгээний төлбөрийн зардал 64.0 тэрбум төг буюу 3 дахин өссөнөөс шалтгаалжээ.

Улсын нэгдсэн төсвийн зарлага ба эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт дүнд урсгал зардал 75.7 хувь, хөрөнгийн зардал 23.4 хувь, эргэж төлөгдөх цэвэр зээл 0.9 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс эргэж төлөгдөх цэвэр зээлийн эзлэх хувь 6.6 пунктээр буурч, хөрөнгийн зардлын эзлэх хувь 6.6 пунктээр өсчээ (Хавсралт 5).

### Хөрөнгийн зардал

Хөрөнгийн зардалд 2012 оны эхний 10 сард 1057.4 тэрбум төг зарцуулсан нь өмнөх оны мөн үеийнхээс 505.2 тэрбум төг буюу 91.5 хувиар нэмэгджээ. Энэ нь дотоодын эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 490.1 тэрбум төг буюу 96.2 хувь, гадаад эх үүсвэрээс зарцуулсан хөрөнгийн зардал 15.0 тэрбум төг буюу 35.4 хувиар өссөнөөс шалтгаалсан байна.

## III.4 Гадаад худалдаа

Монгол Улс 2012 оны эхний 10 сард дэлхийн 135 оронтой худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 9404.0 сая ам.долл, үүнээс экспорт 3664.7 сая ам.долл, импорт 5739.3 сая ам.долларт хүрчээ (Зураг II.21). Өмнөх оны мөн үеийнхээс нийт бараа эргэлтийн хэмжээ 304.3 сая ам.долл буюу 3.3 хувь, импортын хэмжээ 386.9 сая ам.долл буюу 7.2 хувиар өсч, экспортын хэмжээ 82.7 сая ам.долл буюу 2.2 хувиар буурчээ.

Өмнөх оны эхний 10 сард гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.3 хувь нь БНХАУ-д, 15.1 хувь нь ОХУ-д, үлдсэн 28.6 хувь нь бусад улсад ногдож байсан бол 2012 оны эхний 10 сард нийт бараа эргэлтийн 53.7 хувь нь БНХАУ, 17.0 хувь нь ОХУ, 29.3 хувь нь бусад улсад ногдож байна. Өмнөх оны мөн үеийнхээс ОХУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 1.9 пункт, бусад улсынх 0.7 пунктээр өсч, БНХАУ-тай хийсэн бараа эргэлтийн эзлэх хувь 2.6 пунктээр буурчээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 10 сард 2074.6 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 469.6 сая ам.долл буюу 29.3 хувиар өсчээ. Үүнд импортын өмнөх оны мөн үеийнхээс өссөн өсөлт экспортынхоос 9.4 пунктээр илүү байгаа нь нөлөөлсөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2011 оны 10 дугаар сард 219.2 сая ам.долларын алдагдалтай гарсан бол 2012 оны 10 дугаар сард 60.4 сая ам.долларын алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 158.7 сая ам.долл буюу 72.4 хувиар буурчээ.

Зураг-II.21

**Гадаад худалдааны нийт бараа эргэлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая ам.долл**




Зураг-II.22

**Экспортын бүтэц, голлох улсаар, 2012 оны эхний 10 сарын байдлаар**



## Экспорт

Манай улс 2012 оны эхний 10 сард нийт 55 оронд бараа, бүтээгдэхүүн экспортолсноос БНХАУ-д 93.2 хувь, Канад улсад 2.2 хувь, ОХУ-д 1.7 хувь ногдож байгаа нь нийт экспортын 97.1 хувийг эзэлж байна (Зураг II.21).

Экспортын 98.2 хувийг эрдэс бүтээгдэхүүн, үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос, түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, тэдгээрээр хийсэн эдлэл, нэхмэл бүтээгдэхүүн эзэлж байна (Хүснэгт II.6).

Экспортын дүнд нүүрс 44.4 хувь, зэсийн баяжмал 19.0 хувь, төмрийн хүдэр 11.9 хувь, боловсруулаагүй газрын тос 7.4 хувь, цайрын хүдэр, баяжмал 2.8 хувь, жоншны хүдэр, баяжмал болон боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт тус бүр 2.3 хувь, бусад бүтээгдэхүүн 9.9 хувийг эзэлж байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт экспортод зэсийн баяжмалын эзлэх хувь 3.1 пункт, цайрын хүдэр, баяжмалынх 0.5 пункт, боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алтных 0.3 пунктээр буурч, төмрийн хүдрийнх 2.6 пункт, боловсруулаагүй газрын тосных 2.0 пункт, нүүрснийх 1.2 пункт, жоншны хүдэр, баяжмалынх 0.2 пунктээр өссөн байна.

Хүснэгт-II.6

**Экспортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**

| | 2010 I-X | 2011 I-X | 2012 I-X |
|---|---|---|---|
| Нийт | 100.0 | 100.0 | 100.0 |
| Эрдэс бүтээгдэхүүн | 79.6 | 88.1 | 89.4 |
| Нэхмэл болон нэхмэл бүтээгдэхүүн | 8.3 | 6.0 | 5.9 |
| Үнэт ба хагас үнэт чулуу, үнэт металл, гоёлын зүйлс, зоос | 6.8 | 2.6 | 2.3 |
| Түүхий болон боловсруулсан арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл | 1.3 | 1.1 | 0.6 |
| Бусад | 4.0 | 2.2 | 1.8 |

Хүснэгт-II.7

**Экспортолсон зарим эрдэс бүтээгдэхүүн, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, мян.т**

| | 2010 I-X | 2011 I-X | 2012 I-X |
|---|---|---|---|
| Нүүрс | 12 710.9 | 15 694.1 | 16 546.5 |
| Зэсийн баяжмал | 481.7 | 475.2 | 479.1 |
| Төмрийн хүдэр | 2 777.6 | 4 768.7 | 5 311.6 |
| Боловсруулаагүй газрын тос (мян.баррел) | 1 702.2 | 2 007.2 | 2 834.8 |
| Цайрын хүдэр, баяжмал | 87.9 | 100.8 | 110.8 |
| Боловсруулаагүй болон хагас боловсруулсан алт | 4.5 | 2.3 | 2.0 |

## Импорт

Манай улс 2012 оны эхний 10 сард нийт 131 оронтой импортын худалдаа хийсний 28.5 хувийг БНХАУ-тай, 26.8 хувийг ОХУ-тай, 8.3 хувийг АНУ-тай, 7.6 хувийг Япон улстай, 7.0 хувийг БНСУ-тай, 3.6 хувийг ХБНГУ-тай хийсэн нь нийт дүнгийн 81.8 хувийг эзэлж байна (Зураг II.23). Импортын нийт хэмжээнд зарим орнуудын эзлэх хувийг өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад ОХУ-ынх 2.5 пункт, БНСУ-ынх 1.5 пункт, АНУ-ынх 0.4 пункт, Япон улсынх 0.4 пунктээр өсч, БНХАУ-ынх 3.2 пункт, ХБНГУ-ынх 1.0 пункт, бусад улсынх 0.6 пунктээр буурчээ.

Зураг-II.23

**Импортын бүтэц, голлох улсаар, 2012 оны эхний 10 сарын байдлаар**




Импортын хэмжээ 2012 оны эхний 10 сард өмнөх оны мөн үеийнхээс 386.9 сая ам.долл буюу 7.2 хувиар нэмэгдэхэд эрдэс бүтээгдэхүүний импорт 284.4 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 59.5 сая ам.долл, хими, химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийх 45.2 сая ам.долл, хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсгийнх 29.6 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлөв.

Нийт импортод машин, механик төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, дуу хураагч, зурагт, тэдгээрийн эд анги, сэлбэг 24.7 хувь, эрдэс бүтээгдэхүүн 22.4 хувь, авто, агаарын замын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 19.8 хувь, үндсэн төмөрлөг, түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.0 хувь, хүнсний бэлэн

бүтээгдэхүүн 5.6 хувийг эзэлж, үлдсэн 18.5 хувийг бусад бүлгийн бүтээгдэхүүн эзэлж байна (Зураг II.24).

Өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2012 оны эхний 10 сард импортолсон гурил биет хэмжээгээр 6.0 мян.т, үнийн дүнгээр 4.6 сая ам.долл, суудлын автомашин биет хэмжээгээр 4655 ширхэгээр буурч, суудлын автомашин үнийн дүнгээр 31.9 сая ам.долл, цахилгаан эрчим хүч биет хэмжээгээр 104.3 сая квт.ц, үнийн дүнгээр 6.8 сая ам.долл, автобензин биет хэмжээгээр 48.1 мян.т, үнийн дүнгээр 99.7 сая ам.доллараар өсчээ (Зураг II.25).

Газрын тосны бүтээгдэхүүний импорт 2012 оны эхний 10 сард 946.7 мян.т буюу 1120.3 сая ам.долл болж, нийт импортын үнийн дүнгийн 19.5 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 128.4 мян.т буюу 15.7 хувиар өссөн байна.

2012 оны эхний 10 сард газрын тосны бүтээгдэхүүнийг ОХУ, Белорусь улс, БНСУ-аас; гурилыг ОХУ болон Казахстан улсаас; элсэн чихрийг Тайланд, ХБНГУ-аас; нийтийн тээврийн хэрэгслийг БНСУ, ОХУ-аас; суудлын автомашиныг Япон, БНСУ, ХБНГУ, АНУ, Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсаас; ачааны автомашиныг АНУ, БНХАУ, БНСУ, Белорусь улсаас голлон авсан байна.

Импортолсон барааны 86.8 хувийг валютын төлбөртэй худалдаа, 10.9 хувийг гадаадын хөрөнгө оруулалтын бараа, 2.1 хувийг тусламжийн бараа, үлдсэн 0.2 хувийг бусад төрлийн худалдаа эзэлж байна.

## III. Үйлдвэрлэл, үйлчилгээ

### III.1 Газар тариалан

Улсын хэмжээгээр 2012 оны 11 дүгээр сарын 1-ний байдлаар 470.5 мян.т үр тариа, 245.6 мян.т төмс, 97.8 мян.т хүнсний ногоо хураалж, 1140.0 мян.т хадлан, 33.8 мян.т гар тэжээл, 975.3 т дарш бэлтгэсэн нь өмнөх оны мөн үеийнхээс төмс 46.3 мян.т буюу 23.2 хувь, үр тариа 25.2 мян.т буюу 5.7 хувиар нэмэгдэж, харин дарш 1.3 мян.т буюу 2.3 дахин, гар тэжээл 9.3 мян.т буюу 21.5 хувь, хадлан 5.3 мян.т буюу 0.5 хувь, хүнсний ногоо 0.5 мян.т буюу 0.5 хувиар буурсан байна.

Га тутмаас 16.1 цн үр тариа, 150.9 цн төмс хураасан нь өмнөх оны мөн үеийнхээс үр тариа 0.8 цн буюу 5.2 хувь, төмс 20.7 цн буюу 15.9 хувиар илүү байна. Үр тарианы га-гийн ургац Сэлэнгэ, Баянхонгор, Төв, Баян-Өлгий, Орхон аймагт улсын дунджаас 0.8-7.5

Зураг-II.24

**Импортын бүтэц, барааны голлох бүлгээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**




Зураг-II.25

**Зарим барааны импорт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, мян.ам.долл**




Зураг-III.1

**Хураасан үр тариа, мян.т жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний байдлаар**



центнерээр өндөр, Өвөрхангай аймагт улсын дунджийн түвшинд, харин бусад аймагт 0.5-10.3 центнерээр доогуур байна.

Бүсээр авч үзэхэд хураасан үр тарианы 75.3 хувь нь Төвийн, 16.4 хувь нь Хангайн, 6.0 хувь нь Зүүн, 2.3 хувь нь Баруун бүсэд ногдож байна. Хураасан үр тарианы 49.8 хувь нь Сэлэнгэ, 22.8 хувь нь Төв, 9.8 хувь нь Булган, 3.8 хувь нь Хөвсгөл аймагт ногдож байна.

Төмсний га-гийн ургац Сэлэнгэ, Төв аймагт улсын дунджаас 18.7-48.2 центнерээр өндөр, харин бусад аймагт 6.7-124.0 центнерээр доогуур байна. Төмсний 41.0 хувь нь Төв, 25.3 хувь нь Сэлэнгэ, 5.9 хувь нь Ховд, 5.8 хувь нь Дархан-Уул, 3.6 хувь нь Булган аймагт, үлдсэн 18.4 хувь нь нийслэл, бусад аймагт ногдож байна.

Хураасан нийт хүнсний ногооны 33.9 мян.т буюу 34.7 хувь нь Сэлэнгэ, 12.9 мян.т буюу 13.2 хувь нь Дархан-Уул, 11.3 мян.т буюу 11.6 хувь нь Ховд, 11.3 мян.т буюу 11.5 хувь нь Төв аймагт ногдож байна.

Бэлтгэсэн нийт хадлангийн 174.6 мян.т буюу 15.3 хувь нь Сэлэнгэ, 166.0 мян.т буюу 14.6 хувь нь Хөвсгөл, 135.4 мян.т буюу 11.9 хувь нь Хэнтий, 99.7 мян.т буюу 8.7 хувь нь Булган, 86.6 мян.т буюу 7.6 хувь нь Төв, 82.5 мян.т буюу 7.2 хувь нь Архангай, 62.5 мян.т буюу 5.5 хувь нь Ховд, 60.1 мян.т буюу 5.3 хувь нь Дархан-Уул аймагт, 58.3 мян.т буюу 5.1 хувь нь Баян-Өлгий аймагт, үлдсэн 214.3 мян.т буюу 18.8 хувь нь нийслэл, бусад аймагт ногдож байна.

Зураг-III.2

**Хураасан төмс, хүнсний ногоо, мян.т**
**жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний байдлаар**




Зураг-III.3

**Бэлтгэсэн хадлан, мян.т**
**жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний байдлаар**




## III.2 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2012 оны эхний 10 сард 1776.3 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 104.8 тэрбум төг буюу 6.3 хувиар өслөө. Энэхүү өсөлтөд 35 хувийн агуулгад шилжүүлснээр зэсийн баяжмал, молибдений баяжмал, металл агуулгаараа, цайрын баяжмал, төмрийн хүдэр, газрын тос зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.6-47.9 хувь; хиаман төрлийн бүтээгдэхүүн, гурил, малын тэжээл, сүлжмэл эдлэл, нарийн боов, архи, хивс, металл цувимал, зүсмэл материал, цэвэр ус, талх, шар айраг, цахилгааны утас, шингэн сүү, малын мах, шахмал түлш, шавардлагын зуурмаг, бетон дэр зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын үндсэн нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1.7 хувиас 4.7 дахин нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Харин 47 хувийн агуулгад шилжүүлснээр молибдений баяжмал, алт, нүүрс, хайлуур жоншны баяжмал зэрэг уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.9-14.5 хувь; амтат ус, ундаа, катодын зэс, тамхи, спирт, цемент, самнасан ноолуур, нэхий дээл, тэмээний ноосон хөнжил зэрэг боловсруулах аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 0.3-82.1 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл оны үнээр 2012 оны эхний 10 сард 4616.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 474.5 тэрбум төг буюу 11.5 хувиар өссөнөөс уул уурхай, олборлох аж үйлдвэрийнх 188.1 тэрбум төг буюу 6.4 хувь,

боловсруулах аж үйлдвэрийнх 248.5 тэрбум төг буюу 27.7 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 37.9 тэрбум төг буюу 11.7 хувиар өсчээ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 10 сард оны үнээр 4906.4 тэрбум төг болж, 3195.7 тэрбум төг буюу 65.1 хувийг гадаад зах зээлд борлуулжээ (Хавсралт 9).

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 10 сард 59.9 хувь нь уул уурхай, олборлох аж үйлдвэрт, 32.7 хувь нь боловсруулах аж үйлдвэрт, 7.4 хувь нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт ногдож байна (Зураг III.6). Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 2012 оны эхний 10 сард 2942.6 тэрбум төг болж, 2584.5 тэрбум төг буюу 87.8 хувийг гадаад зах зээлд, боловсруулах аж үйлдвэрийн борлуулсан бүтээгдэхүүн 1602.6 тэрбум төг болж, 611.2 тэрбум төг буюу 38.1 хувийг нь гадаад зах зээлд борлуулав.

Нийт борлуулалтад боловсруулах аж үйлдвэрийн салбарын эзлэх хувь 2012 оны эхний 10 сард 32.7 хувь болж, өмнөх оны мөн үеийнхээс 6.8 пункт, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарынх 7.4 хувь болж, 0.3 пунктээр нэмэгдэж, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарынх 59.9 хувь болж, 7.1 пунктээр буурлаа (Зураг III.6).

Аж үйлдвэрийн салбарт ажиллагчдын тоо 2012 оны 10 дугаар сарын эцэст 62186 болж, өмнөх оны мөн үеийнхээс 4366 хүн буюу 7.6 хувиар өсчээ. Ажиллагчдын тоо уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 2147 хүн буюу 11.7 хувь, боловсруулах аж үйлдвэрийн салбарт 2060 хүн буюу 8.2 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 159 хүн буюу 1.1 хувиар өслөө.

Аж үйлдвэрийн салбарын хөдөлмөрийн бүтээмж (2005 оны зэрэгцүүлэх үнээр) 2012 оны эхний 10 сард 30989.5 мян.төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 26.9 мян.төг буюу 0.1 хувиар өсчээ. Хөдөлмөрийн бүтээмж боловсруулах аж үйлдвэрийн салбарт 133.8 мян.төг буюу 0.6 хувь, цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамжийн салбарт 374.0 мян.төг буюу 2.9 хувиар өсч, харин уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарт 1213.2 мян.төг буюу 2.1 хувиар буурлаа.

Зураг-III.4

**Уул уурхайн зарим гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өөрчлөлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар, 2005 I-X=100%**




Зураг-III.5

**Түлш, эрчим хүчний гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар, 2005 I-X =100%**




Зураг-III.6

**Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний борлуулалтын бүтэц, дэд салбараар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, хувиар**



## III.3 Дотоод худалдаа

Улсын хэмжээнд 2012 оны эхний 9 сард нийт 51443 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаагийн 17629 буюу 34.3 хувь нь бөөний болон жижиглэн худалдааны салбарт үйл ажиллагаа явуулж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувь, борлуулалтын нийт орлогын 90.0 гаруй хувийг жилд 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгж эзэлж байна.

Жилд 50.0 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой нэг аж ахуйн нэгжид ногдох орлого 2010 оны эхний 9 сард 985.1 сая төг, 2011 оны эхний 9 сард 1364.9 сая төг байсан бол 2012 оны эхний 9 сард 3238.4 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 379.8 сая төг буюу 2.4 дахин өсчээ.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын нийт борлуулалт (оны үнээр) 2012 оны эхний 9 сард 3857.0 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 1117.4 тэрбум төг буюу 40.8 хувиар өсчээ.

Өмнөх оны мөн үеийнхээс бөөний худалдааны борлуулалт 807.1 тэрбум төг буюу 45.1 хувиар, жижиглэн худалдааных 310.4 тэрбум төг буюу 32.7 хувиар өслөө (Зураг III.7).

Зураг-III.7

**Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төг**




Хүснэгт-III.1

**Бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар**

сая төг

| Дэд салбар | 2010 I-IX | 2011 I-IX | 2012 I-IX | 2012 I-IX / 2011 I-IX % |
|---|---|---|---|---|
| Бүгд | 1 537 616.5 | 2 739 561.5 | 3 856 988.6 | 140.8 |
| Бөөний худалдаа | 827 345.0 | 1 789 260.0 | 2 596 324.8 | 145.1 |
| Жижиглэн худалдаа | 710 271.5 | 950 301.5 | 1 260 663.8 | 132.7 |

Энэ нь импорт өмнөх оны мөн үеийнхээс 419.5 сая ам.долл, үүний дотор эрдэс бүтээгдэхүүний импорт 301.1 сая ам.долл, хүнсний бэлэн бүтээгдэхүүнийх 50.4 сая ам.долл, хими химийн үйлдвэрийн бүтээгдэхүүнийх 36.4 сая ам.долл, хараа зүй, гэрэл, кино зураг, хэмжүүр, хяналт, эмнэлэг, мэс заслын багаж, цаг, хөгжмийн зэмсгийнх 30.0 сая ам.доллараар өссөнөөс голлон шалтгаалав.

Салбарын нийт борлуулалтын 67.3 хувийг бөөний, 32.7 хувийг жижиглэн худалдаа эзэлж байна.

Бөөний болон жижиглэн худалдааны салбарын борлуулалтын 88.5 хувь нь Улаанбаатар хотод ногдож байна.

Худалдааны салбарын нийт борлуулалт өмнөх оны мөн үеийнхээс Сүхбаатар, Дундговь, Архангай, Өмнөговь аймгуудад 2.4-35.4 хувиар буурч, бусад аймаг, Улаанбаатар хотод 11.4 - 65.7 хувиар өсчээ.

Хүснэгт-III.2

**Бөөний болон жижиглэн худалдааны талбайн хэмжээ, борлуулалтын орлогын бүлгээр, 2012 оны эхний 9 сарын байдлаар**

| Борлуулалтын орлого, бүлгээр | Ашигтай талбайн нийт хэмжээ ($м^2$) | Нэг аж ахуйн нэгжид ногдох ашигтай талбай ($м^2$) | Ашигтай талбайн нэг $м^2$-д ногдох дундаж орлого (мян.төг) |
|---|---|---|---|
| 100 сая төг хүртэл | 35 299.8 | 94.4 | 539.8 |
| 101-500 сая төг | 78 565.2 | 192.1 | 1 184.1 |
| 501-1000 сая төг | 41 197.6 | 314.5 | 2 271.0 |
| 1001-5000 сая төг | 109 434.3 | 659.2 | 3 472.9 |
| 5001 сая төгрөгөөс дээш | 293 793.0 | 2 646.8 | 11 134.7 |

Жилийн 5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой аж ахуйн нэгжийн худалдааны ашигтай талбай 2012 оны эхний 9 сард дунджаар 2646.8 ам метр байгаа бол 100 сая төгрөгөөс бага орлоготой жижиг аж ахуйн нэгжийнх 94.4 ам метр байна. (Хүснэгт III.2)

Жилийн 5 тэрбум төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой худалдааны томоохон төвүүдэд нэг ам метр талбайд ногдох дундаж орлого 11.1 сая төг байгаа бол харин 100 сая төгрөгөөс бага борлуулалтын орлоготой жижиг

дэлгүүрийн хувьд энэ үзүүлэлт 539.8 мян.төг байна (Хүснэгт III.2).

Худалдааны салбарын ажлын цагийн үргэлжлэх хугацааг авч үзэхэд нийт аж ахуйн нэгжийн 1.3 хувь нь 8 хүртэл цаг, 94.2 хувь нь 8-10 цаг, 4.5 хувь нь 24 цаг ажиллаж байна.

Худалдааны салбарт ажиллаж байгаа нийт ажиллагчдын 53.6 хувь нь эмэгтэйчүүд байна.

### III.4 Тээвэр

Төмөр замын тээврээр 2012 оны эхний 10 сард 16894.3 мян.т ачаа тээж, давхардсан тоогоор 3365.0 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1707.3 мян.т буюу 11.2 хувь, зорчигчдын тоо 158.6 мян.хүн буюу 4.9 хувиар өсчээ (Зураг III.8.а, III.8.б).

Төмөр замаар тээсэн нийт ачааны хэмжээ өмнөх оны мөн үеийнхээс нэмэгдэхэд дамжин өнгөрсөн ачааны хэмжээ 350.5 мян.т буюу 21.5 хувиар буурсан хэдий ч дотоодод тээвэрлэсэн ачаа 1018.9 мян.т буюу 14.5 хувь, экспортын ачаа 633.8 мян.т буюу 13.0 хувь, импортын ачаа 405.1 мян.т буюу 24.7 хувиар нэмэгдсэн нь нөлөөлөв.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2012 оны 10 дугаар сард 1879.6 мян.т болж, өмнөх сарынхаас 121.1 мян.т буюу 6.9 хувь, зорчигчдын тоо 327.4 мян.хүн болж, 22.9 мян.хүн буюу 7.5 хувь, тээврийн орлого 34.3 тэрбум төг болж, 68.3 сая төг буюу 0.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 161.6 мян.т буюу 9.4 хувиар өсч, зорчигчдын тоо 3.9 мян.хүн буюу 1.2 хувь, орлого 1.1 тэрбум төг буюу 3.1 хувиар буурчээ (Зураг III.9.а, III.9.б).

Төмөр замын нийт ачаа тээвэрлэлтэд 2012 оны эхний 10 сард экспортын ачаа 32.6 хувь, дотоодод тээвэрлэсэн ачаа 47.7 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс экспортын ачаа 0.5 пункт, дотоодод тээвэрлэсэн ачаа 1.3 пунктээр нэмэгдэхэд барилгын материалын тээвэрлэлт 658.2 мян.т буюу 50.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Төмөр замын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 10 сард 347.4 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 23.6 тэрбум төг буюу 7.3 хувиар өсчээ (Хүснэгт III.3).

Зураг-III.8.а

**Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.8.б

**Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, мян.т**




Зураг-III.9.а

**Төмөр замын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.9.б

**Төмөр замын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, мян.т**



Хүснэгт-III.3

**Төмөр замын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар**

| Хугацаа, сараар | Тээврийн орлого, сая төг | Зорчигчдын тоо, мян.хүн | Тээсэн ачаа, мян.т |
|---|---|---|---|
| 2010 I | 19 860.5 | 257.9 | 1 277.8 |
| II | 18 766.2 | 294.5 | 1 169.5 |
| III | 21 037.8 | 248.3 | 1 198.9 |
| IV | 21 538.6 | 259.7 | 1 222.3 |
| V | 24 687.0 | 301.1 | 1 268.5 |
| VI | 26 479.8 | 316.3 | 1 366.0 |
| VII | 27 888.0 | 316.6 | 1 434.2 |
| VIII | 30 577.3 | 364.4 | 1 556.3 |
| IX | 29 608.3 | 269.5 | 1 646.9 |
| X | 30 339.3 | 294.4 | 1 578.7 |
| 2010 I-X | 250 782.9 | 2 922.8 | 13 719.1 |
| 2011 I | 24 937.1 | 293.0 | 1 345.0 |
| II | 21 280.4 | 279.7 | 1 244.0 |
| III | 27 989.6 | 281.1 | 1 436.8 |
| IV | 32 225.5 | 301.1 | 1 494.0 |
| V | 33 386.3 | 324.6 | 1 489.1 |
| VI | 34 575.4 | 341.6 | 1 515.9 |
| VII | 39 427.6 | 363.3 | 1 630.2 |
| VIII | 40 291.6 | 385.8 | 1 615.2 |
| IX | 34 229.6 | 305.0 | 1 698.7 |
| X | 35 385.1 | 331.3 | 1 718.0 |
| 2011 I-X | 323 728.1 | 3 206.4 | 15 187.0 |
| 2012 I | 32 900.5 | 293.7 | 1 733.8 |
| II | 35 161.1 | 316.2 | 1 529.2 |
| III | 32 191.4 | 305.0 | 1 682.6 |
| IV | 33 370.1 | 321.6 | 1 698.2 |
| V | 38 648.1 | 358.0 | 1 692.7 |
| VI | 36 092.4 | 361.8 | 1 614.8 |
| VII | 33 433.3 | 388.5 | 1 573.7 |
| VIII | 37 070.9 | 388.4 | 1 731.3 |
| IX | 34 208.6 | 304.5 | 1 758.5 |
| X | 34 276.9 | 327.4 | 1 879.6 |
| 2012 I-X | 347 353.2 | 3 365.0 | 16 894.3 |
| 2012 I-X / 2011 I-X % | 107.3 | 104.9 | 111.2 |
| 2012 X / 2011 X % | 96.9 | 98.8 | 109.4 |
| 2012 X / 2012 IX % | 100.2 | 107.5 | 106.9 |

Агаарын тээврээр 2012 оны эхний 10 сард 3385.4 т ачаа тээж, давхардсан тоогоор 654.8 мян.зорчигч зорчсон нь өмнөх оны мөн үеийнхээс тээсэн ачаа 1141.8 т буюу 50.9 хувь, зорчигчдын тоо 178.0 мян.хүн буюу 37.3 хувиар өсчээ (Зураг III.10.а, III.10.б).

Агаарын тээврээр тээсэн ачаа 2012 оны 10 дугаар сард 323.9 т болж өмнөх сарынхаас 48.3 т буюу 13.0 хувь, зорчигчдын тоо 63.9 мян.хүн болж, 5.6 мян.хүн буюу 8.1 хувиар буурч, харин орлого 19.3 тэрбум төг болж, 2.6 тэрбум төг буюу 15.3 хувь, өмнөх оны мөн үеийнхээс орлого 5.7 тэрбум төг буюу 42.4 хувь, зорчигчдын тоо 17.0 мян.хүн буюу 36.3 хувиар өсч, тээсэн ачаа 18.0 т буюу 5.3 хувиар буурсан байна (Зураг III.11.а, III.11.б).

Агаарын тээврээр 2012 оны эхний 10 сард дотоодод зорчсон зорчигчдын тоо өмнөх оны мөн үеийнхээс 115.6 мян.хүн буюу 72.4 хувь,

Зураг-III.10.а

**Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.10.б

**Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, т**




Зураг-III.11.а

**Агаарын тээврээр зорчигчдын тоо, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, мян.хүн**




Зураг-III.11.б

**Агаарын тээврээр тээсэн ачаа, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, т**



олон улсад зорчсон зорчигчдын тоо 62.4 мян. хүн буюу 19.7 хувиар өсчээ.

Тээсэн ачаа, зорчигчдын тоо өссөнөөр агаарын тээврийн салбарын орлого 2012 оны эхний 10 сард 162.1 тэрбум төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 24.3 тэрбум төг буюу 17.6 хувиар нэмэгдэв (Хүснэгт III.4).

## III.5 Зочид буудал, зоогийн газар

### Нийтийн хоол.

Нийтийн хоолны салбарын мэдээнд 2012 оны эхний 9 сард 608 аж ахуйн нэгж хамрагдсан нь салбартаа үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн 38.5 хувь, нийт орлогын 85.0 гаруй хувийг эзэлж байна.

Эдгээр аж ахуйн нэгжийн нийт орлого 2012 оны эхний 9 сард 104.7 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеийнхээс 37.3 тэрбум төг буюу 55.5 хувиар нэмэгдэхэд гуанзны орлого 4.2 тэрбум төг буюу 2.0 дахин, кафеных 4.5 тэрбум төг буюу 96.7 хувь, рестораных 11.9 тэрбум төг буюу 63.1 хувь, тусгай захиалгат хоолоор үйлчилдэг аж ахуйн нэгжийнх 16.1 тэрбум төг буюу 43.2 хувь, баарных 760.9 сая төг буюу 28.9 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.

Нийтийн хоолны салбарын мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжийн нэг суудалд ногдох дундаж орлого 2012 оны эхний 9 сард дунджаар 1.7 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс 436.9 мян.төг буюу 34.0 хувиар өсчээ. Өмнөх оны мөн үеийнхээс кафены нэг суудалд ногдох дундаж орлого 488.8 мян.төг буюу 54.4 хувь, гуанзных 453.4 мян.төг буюу 52.4 хувь, рестораных 657.3 мян.төг буюу 31.2 хувь, баарных 6.5 мян.төг буюу 1.2 хувиар өсчээ (Хүснэгт III.5).

Хүснэгт-III.4

**Агаарын тээврийн орлого, зорчигчдын тоо болон тээсэн ачаа, сараар**

| Хугацаа, сараар | Тээврийн орлого, сая төг | Зорчигчдын тоо, мян.хүн | Тээсэн ачаа, т |
|---|---|---|---|
| 2010 I | 6 759.1 | 24.1 | 138.5 |
| II | 6 096.3 | 19.8 | 102.1 |
| III | 7 206.7 | 24.2 | 104.1 |
| IV | 6 648.5 | 22.1 | 96.4 |
| V | 10 295.7 | 26.5 | 108.6 |
| VI | 8 207.6 | 37.6 | 123.4 |
| VII | 16 239.8 | 51.4 | 161.1 |
| VIII | 18 690.2 | 55.1 | 272.3 |
| IX | 9 650.3 | 37.9 | 141.9 |
| X | 8 353.0 | 32.7 | 126.9 |
| 2010 I-X | 98 147.3 | 331.4 | 1 375.3 |
| 2011 I | 9 021.4 | 36.5 | 128.6 |
| II | 9 021.2 | 29.2 | 123.5 |
| III | 8 204.8 | 35.0 | 152.1 |
| IV | 9 825.9 | 37.3 | 153.1 |
| V | 10 220.4 | 41.5 | 142.8 |
| VI | 16 462.4 | 54.8 | 259.1 |
| VII | 21 130.2 | 71.4 | 319.4 |
| VIII | 25 242.6 | 73.3 | 347.5 |
| IX | 15 157.0 | 51.1 | 275.7 |
| X | 13 527.6 | 46.9 | 341.9 |
| 2011 I-X | 137 813.4 | 476.8 | 2 243.6 |
| 2012 I | 11 564.5 | 46.2 | 302.3 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 315.3 | 263.8 | 2 196.3 | 2 203.8 | 100.3 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 289.3 | 289.7 | 2 348.0 | 3 485.7 | 148.5 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 801.2 | 1 829.3 | 8 046.2 | 13 006.3 | 161.6 |
| Кокс, шахмал түлш үйлдвэрлэл | 32.4 | 307.2 | 318.7 | 955.4 | 299.8 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 3 147.3 | 1 655.4 | 18 801.7 | 17 191.9 | 91.4 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 173.5 | 860.7 | 2 078.7 | 8 434.9 | 405.8 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 7 038.1 | 8 035.1 | 46 923.8 | 54 029.1 | 115.1 |
| Төмрийн үйлдвэрлэл | 6 795.5 | 5 062.2 | 49 864.5 | 53 506.9 | 107.3 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 5.0 | 3.9 | 32.7 | 70.2 | 214.5 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 18.7 | 24.3 | 752.7 | 3 884.9 | 516.2 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 488.1 | 88.6 | 2 947.5 | 3 538.6 | 120.1 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл | 1.1 | 0.7 | 68.3 | 6.9 | 10.0 |
| Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл | 37.1 | 97.4 | 387.6 | 733.3 | 189.2 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 58.8 | 130.9 | 782.8 | 2 567.8 | 328.0 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлт, усан хангамж** | **19 681.2** | **20 913.1** | **177 164.0** | **184 701.5** | **104.3** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 18 520.5 | 19 714.1 | 165 885.8 | 173 271.2 | 104.5 |
| Ус ариутгал, усан хангамж | 1 160.7 | 1 199.0 | 11 278.3 | 11 430.2 | 101.3 |

Хавсралт № 11

**Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн зарим бүтээгдэхүүний үйлдвэрлэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**

| Нэр төрөл | Хэмжих нэгж | 2011 X | 2012 X | 2011 I-X | 2012 I-X | $\frac{2012\ I\text{-}X}{2011\ I\text{-}X}$ % |
|---|---|---|---|---|---|---|
| Цахилгаан эрчим хүч | сая кВт.цаг | 341.2 | 357.7 | 3 106.9 | 3 279.2 | 105.5 |
| Дулааны эрчим хүч | мян.Гкал | 714.4 | 797.6 | 6 058.0 | 6 098.6 | 100.7 |
| Газрын тос | мян.баррел | 247.6 | 358.3 | 1 948.0 | 2 880.4 | 147.9 |
| Нүүрс | мян.т | 3 294.0 | 2 925.9 | 24 059.0 | 21 784.8 | 90.5 |
| Зэсийн баяжмал, 35%-ийн агуулгад шилжүүлснээр | мян.т | 30.9 | 29.6 | 289.1 | 290.8 | 100.6 |
| Молибдений баяжмал, 47%-ийн агуулгад шилжүүлснээр | т | 351.4 | 343.6 | 3 426.0 | 3 395.0 | 99.1 |
| Хайлуур жоншны баяжмал | мян.т | 6.1 | 6.8 | 108.3 | 92.6 | 85.5 |
| Алт | кг | 570.4 | 672.2 | 5 007.6 | 4 834.7 | 96.5 |
| Катодын зэс, 99% | т | 200.6 | 228.8 | 1 981.2 | 1 898.1 | 95.8 |
| Сүлжмэл эдлэл | мян.ш | 84.2 | 64.0 | 622.7 | 657.4 | 105.6 |
| Самнасан ноолуур | т | 36.9 | 65.4 | 852.2 | 367.0 | 43.1 |
| Хивс | мян.$м^2$ | 79.8 | 88.1 | 680.4 | 744.4 | 109.4 |
| Тэмээний ноосон хөнжил | мян.м | 2.2 | 1.1 | 20.7 | 3.7 | 17.9 |
| Зүсмэл материал | $м^3$ | 1 436.0 | 640.3 | 9 600.0 | 10 576.5 | 110.2 |
| Шохой | мян.т | 6.9 | 6.2 | 35.4 | 57.7 | 163.2 |
| Сонин | сая х.д.х | 3.7 | 5.4 | 33.2 | 53.6 | 161.4 |
| Малын мах | т | 1 140.6 | 2 768.8 | 2443.6 | 4 127.0 | 168.9 |
| Хиаман төрлийн бүтээгдэхүүн | т | 231.1 | 197.5 | 1 772.3 | 1 802.8 | 101.7 |
| Гурил | т | 8 568.0 | 7 540.3 | 80 941.2 | 83 049.3 | 102.6 |
| Талх | т | 2 281.0 | 2 312.3 | 18 739.8 | 20 752.7 | 110.7 |
| Нарийн боов | т | 1 237.9 | 1 250.8 | 10 570.1 | 11 170.7 | 105.7 |
| Гоймон | т | 204.5 | 390.1 | 1 792.3 | 2 653.3 | 148.0 |
| Амтат ус, ундаа | мян.л | 7 495.1 | 5 516.8 | 65 440.0 | 65 240.2 | 99.7 |
| Архи, дарс | мян.л | 2 057.0 | 2 189.9 | 21 429.8 | 23 164.2 | 108.1 |
| Спирт | мян.л | 460.9 | 313.4 | 2 940.0 | 2 700.6 | 91.9 |

Хавсралт № 12

**Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн, салбараар, оны үнээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**

сая төг

| Аж үйлдвэрийн салбар | 2011 I-X | 2012 I-X | Үүнээс: гадаадад | Дүнд эзлэх хувь | |
|---|---|---|---|---|---|
| | | | | 2011 I-X | 2012 I-X |
| **Аж үйлдвэр бүгд** | **4 567 962.7** | **4 906 388.6** | **3 195 709.4** | **100.0** | **100.0** |
| **Уул уурхай, олборлох аж үйлдвэр** | **3 061 445.0** | **2 942 584.9** | **2 584 526.6** | **67.0** | **59.9** |
| Нүүрс олборлолт | 1 104 231.0 | 823 422.0 | 710 754.9 | 24.2 | 16.8 |
| Газрын тос олборлолт | 237 618.2 | 368 735.4 | 368 735.4 | 5.2 | 7.5 |
| Металлын хүдэр олборлолт | 1 651 969.3 | 1 694 066.7 | 1 460 399.0 | 36.2 | 34.5 |
| Бусад ашигт малтмал олборлолт | 67 626.5 | 56 360.8 | 44 637.3 | 1.5 | 1.1 |
| **Боловсруулах аж үйлдвэр** | **1 182 865.7** | **1 602 600.6** | **611 182.8** | **25.9** | **32.7** |
| Хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл | 523 384.2 | 603 177.5 | 4 426.7 | 11.5 | 12.3 |
| Мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт | 31 010.7 | 52 413.0 | 3 714.2 | 5.9 * | 8.7 * |
| Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 30 315.9 | 33 196.7 | - | 5.8 * | 5.5 * |
| Үр тарианы гурил, цардуул, малын тэжээл үйлдвэрлэл | 100 989.9 | 46 183.5 | - | 19.3 * | 7.7 * |
| Хүнсний бусад бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 56 600.5 | 65 660.7 | - | 10.8 * | 10.9 * |
| Ундаа үйлдвэрлэл /согтууруулах ундаа ороод/ | 304 467.3 | 405 723.6 | 712.5 | 58.2 * | 67.3 * |
| Тамхи үйлдвэрлэл | 35 145.6 | 36 809.0 | - | 0.8 | 0.8 |
| Нэхмэлийн үйлдвэрлэл | 158 935.3 | 146 179.0 | 87 826.4 | 3.5 | 3.0 |
| Хувцас үйлдвэрлэл, үслэг арьс боловсруулалт | 8 571.9 | 10 285.5 | 1 639.8 | 0.2 | 0.2 |
| Арьс, шир боловсруулах, ширэн эдлэл, гутал үйлдвэрлэл | 1 911.5 | 6 590.3 | 4 811.7 | 0.0 | 0.1 |
| Мод, модон эдлэл үйлдвэрлэл | 7 554.4 | 12 038.2 | - | 0.2 | 0.2 |
| Нийтлэх, хэвлэх, дуу бичлэг хийх ажиллагаа | 13 059.7 | 20 215.0 | - | 0.3 | 0.4 |
| Цаас, цаасан бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 9 418.2 | 13 040.1 | - | 0.2 | 0.3 |
| Кокс, шахмал түлш үйлдвэрлэл | 204 058.7 | 457 640.5 | 456 264.7 | 4.5 | 9.3 |
| Химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл | 33 801.8 | 44 496.2 | - | 0.7 | 0.9 |
| Резин болон хуванцар бүтээгдэхүүн | 2 652.3 | 2 788.9 | - | 0.1 | 0.1 |
| Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл | 86 778.5 | 106 658.7 | - | 1.9 | 2.2 |
| Төмрийн үйлдвэрлэл | 74 105.9 | 105 505.9 | 55 816.2 | 1.6 | 2.2 |
| Машин, тоног төхөөрөмжөөс бусад төмөр эдлэл үйлдвэрлэл | 18 197.2 | 27 177.6 | 394.0 | 0.4 | 0.6 |
| Бичиг хэргийн болон тооцоолох техник үйлдвэрлэл | 1 288.4 | 2 757.8 | - | 0.0 | 0.1 |
| Цахилгаан хэрэгсэл үйлдвэрлэл | 775.4 | 2 327.3 | - | 0.0 | 0.0 |
| Эмнэлгийн багаж хэрэгсэл, нарийн хэмжүүр, хараа зүйн хэрэгсэл үйлдвэрлэл | 216.2 | 174.2 | - | 0.0 | 0.0 |
| Тээврийн бусад хэрэгсэл үйлдвэрлэл | 1 852.1 | 3 157.7 | - | 0.0 | 0.1 |
| Тавилга үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрийн бусад | 1 158.2 | 1 581.1 | 3.4 | 0.0 | 0.0 |
| **Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэл, усан хангамж** | **323 652.0** | **361 203.1** | **-** | **7.1** | **7.4** |
| Цахилгаан, дулаан, уур үйлдвэрлэл | 292 065.6 | 327 292.7 | - | 6.4 | 6.7 |
| Ус ариутгал, усан хангамж | 31 586.4 | 33 910.4 | - | 0.7 | 0.7 |

Тайлбар: * Бүлгийн дүнд эзлэх хувь

Хавсралт № 13

**Төмөр зам, агаарын тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар**

| Тээврийн төрөл, үзүүлэлтүүд | 2010 I-X | 2011 I-X | 2012 I-X | 2012 I-X / 2011 I-X % |
|---|---|---|---|---|
| **I. Төмөр замын тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа, мян.т | 13 719.1 | 15 187.0 | 16 894.3 | 111.2 |
| дотоодын | 6 757.9 | 7 046.7 | 8 065.6 | 114.5 |
| гаргалт | 3 706.6 | 4 869.6 | 5 503.3 | 113.0 |
| оруулалт | 1 254.2 | 1 638.9 | 2 044.0 | 124.7 |
| дамжин өнгөрөх | 2 000.4 | 1 631.8 | 1 281.4 | 78.5 |
| Ачаа эргэлт, сая т.км | 8 453.6 | 9 470.1 | 10 183.1 | 107.5 |
| дотоодын | 2 163.4 | 2 401.5 | 2 754.3 | 114.7 |
| гаргалт | 3 455.3 | 4 405.9 | 4 978.0 | 113.0 |
| оруулалт | 614.5 | 851.5 | 1 028.5 | 120.8 |
| дамжин өнгөрөх | 2 220.4 | 1 811.4 | 1 422.3 | 78.5 |
| Зорчигчдын тоо, мян.хүн | 2 922.8 | 3 206.4 | 3 365.0 | 104.9 |
| олон улсад зорчсон | 120.5 | 140.0 | 140.2 | 100.1 |
| дотоодод зорчсон | 2 802.3 | 3 066.4 | 3 224.9 | 105.2 |
| Зорчигч эргэлт, сая хүн км | 999.6 | 1 163.2 | 1 231.7 | 105.9 |
| Шилжүүлсэн сая т.км | 9 453.2 | 10 633.4 | 11 414.9 | 107.3 |
| Тээврийн орлого, оны үнээр, сая төг | 250 782.9 | 323 728.1 | 347 353.2 | 107.3 |
| **II. Агаарын тээвэр** | | | | |
| Тээсэн ачаа, т | 1 375.3 | 2 243.6 | 3 385.4 | 150.9 |
| шуудан | 308.9 | 349.4 | 345.0 | 98.7 |
| тээш | 230.5 | 330.5 | 386.5 | 116.9 |
| ачаа | 835.9 | 1 563.7 | 2 653.9 | 169.7 |
| Ачаа эргэлт, мян.т.км | 3 641.3 | 5 833.9 | 8 541.8 | 146.4 |
| шуудан | 538.1 | 640.1 | 682.9 | 106.7 |
| тээш | 330.7 | 465.7 | 521.3 | 111.9 |
| ачаа | 2 772.5 | 4 728.2 | 7 337.6 | 155.2 |
| Зорчигчдын тоо, мян.хүн | 331.4 | 476.8 | 654.8 | 137.3 |
| олон улсад зорчсон | 230.7 | 317.1 | 379.5 | 119.7 |
| дотоодод зорчсон | 100.7 | 159.7 | 275.4 | 172.4 |
| Зорчигч эргэлт, сая хүн км | 564.3 | 815.6 | 1 044.7 | 128.1 |
| Шилжүүлсэн сая т.км | 54.8 | 75.9 | 103.4 | 136.3 |
| Тээврийн орлого, оны үнээр, сая төг | 98 147.3 | 137 813.4 | 162 096.6 | 117.6 |

# МОНГОЛ УЛСЫН ХӨГЖИЛ ОЛОН УЛСЫН ТҮВШИНД

## Нэг. Дэлхийн эдийн засгийн өнөөгийн байдал

Дэлхийн 134.2 сая хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 7 050 414 362 хүн1 /2012 оны 11-р сарын 6-ны өдрийн 15 цагийн байдлаар/ амьдарч, дунджаар нэг хавтгай дөрвөлжин километрт 53 хүн ногдож байна. Харин манай улсад нэг хавтгай дөрвөлжин километр нутаг дэвсгэрт 2011 оны байдлаар 2 хүн ногдож байна.

Дэлхийн хэмжээнд 2011 онд 66.2 триллион ам.долларын бүтээгдэхүүн, үйлчилгээ үйлдвэрлэсэн байна. Үүний 45.2 триллион ам.долл буюу 68.2 хувийг дэлхийн нийт хүн амын 16.3 хувь амьдардаг өндөр орлоготой орнууд, үлдсэн 31.8 орчим хувийг хүн амын 83.7 хувь амьдардаг бага болон дундаж орлоготой орнууд үйлдвэрлэжээ.

Дэлхийн үндэсний нийт орлого (ҮНО)-ын (Дэлхийн банкны атласын аргаар тооцсон) 22.8 хувийг АНУ дангаараа үйлдвэрлэж дэлхийн эдийн засгийг тэргүүлсэн хэвээр байна. Үндэсний нийт орлогын хэмжээгээр эхний 5 байранд, дараалаар АНУ, БНХАУ, Япон, ХБНГУ, Франц / 2775.7-15097.1 тэрбум ам.доллар/ орж байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээгээр Норвеги, Швейцарь, Дани, АНУ /48.4-88.9 мянган ам.доллар/ тэргүүлж байна.

Монгол Улс 2010 оны байдлаар ҮНО 5.2 тэрбум ам.доллар буюу 153-р байранд, нэг хүнд ногдох ҮНО 1870 ам.доллараар 155-р байранд орж байна. Манай улс 2007 оны түвшнээс ҮНО-ын нийт хэмжээгээр 3 байраар урагшилж, нэг хүнд ногдох орлогоор 6 байраар ухарсан байна.

Хүснэгт 1

### Хүн амын тоо, үндэсний нийт орлого, дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, улс орны хөгжлийн түвшнээр, 2011 оны байдлаар

| | Хүн ам, сая | ҮНО*, тэрбум ам.доллар | Нэг хүнд ногдох ҮНО*, ам.доллар | ДНБ-ий жилийн өсөлт /хувь/ |
|---|---|---|---|---|
| **ДЭЛХИЙ** | **6973.7** | **66185.0** | **9490.6** | **2.7** |
| **Бага орлоготой орнууд** | 816.8 | 463.0 | 566.8 | 6.0 |
| **Дундаж орлоготой орнууд** | 5021.9 | 20717.3 | 4125.4 | 6.3 |
| Дунджаас бага орлоготой орнууд | 2532.8 | 4457.7 | 1760.0 | 5.5 |
| Дунджаас дээгүүр орлоготой орнууд | 2489.1 | 16253.0 | 6529.7 | 6.6 |
| **Бага ба дунд орлоготой орнууд** | 5838.7 | 21203.3 | 3631.5 | 6.3 |
| Зүүн Ази, Номхон далайн орнууд | 1974.2 | 8376.8 | 4243.1 | 8.3 |
| Европ, Төв Ази | 407.6 | 3101.4 | 7609.7 | 5.7 |
| Латин Америк, Карибын тэнгисийн орнууд | 589.0 | 5032.8 | 8544.4 | 4.7 |
| Ойрхи дорнод, Хойд Африкийн орнууд | 336.6 | ... | ... | ... |
| Өмнөд Азийн орнууд | 1656.5 | 2151.1 | 1298.6 | 6.4 |
| Сахар орчмын Африкийн орнууд | 874.8 | 1098.1 | 1255.2 | 4.1 |
| **Өндөр орлоготой орнууд** | 1135.0 | 45153.9 | 39783 | 1.5 |
| АНУ | 311.6 | 15097.1 | 48450 | 1.7 |
| Япон | 1344.1 | 6644.3 | 4940.0 | 9.3 |

*Тайлбар: * - Атласын аргаар тооцсон*

*Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2012"*

*1 АНУ-ын Тооллогын товчооны тооцоогоор*

Дээрх хүснэгтээс үзэхэд эдийн засгийн өсөлт 2011 онд хамгийн өндөр байгаа Зүүн Ази, Номхон далайн хөгжиж байгаа орнуудын дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий бодит өсөлт дэлхийн дунджаас даруй 3.1 дахин их, харин өндөр орлоготой орнуудынх дэлхийн дунджаас 1.2 пунктээр бага байна.

## Хоёр. Монгол Улсын хөгжлийн зарим үндсэн үзүүлэлтүүдийн олон улсын түвшний харьцуулалт

Дэлхийн банк жил бүр улс орнуудыг нэг хүнд ногдох үндэсний нийт орлогоор нь бага орлоготой, дундаж орлоготой (дунджаас доогуур болон дунджаас дээгүүр), өндөр орлоготой гэж ангилдаг. Манай улс 2007 оноос бага орлоготой орноос дунджаас доогуур орлоготой орны ангилалд шилжин орсон.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн 1990, 1995, 2000, 2005-2011 оны зарим үндсэн үзүүлэлтээр дэлхийн дундаж болон бага, дундаж, өндөр орлоготой орнууд, хөгжлийн ижил түвшний орнуудтай харьцуулалт хийлээ. Энд эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд болон нийгмийн хөгжлийн түвшнийг илэрхийлэх нийт 20 гаруй үзүүлэлтийг ашиглав. Хөгжлийн ижил түвшний улсыг сонгохдоо нэг хүнд ногдох ҮНО-ын (худалдан авах чадварын паритетаар-ХАЧП) хэмжээ, хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээр Монгол Улстай ойр үнэлэгдсэн Молдав, Узбекистан зэрэг улсыг сонгож авсан.

Хүснэгт 2

### Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого, хүний хөгжлийн индекс, 2010 он

| Улс | Эзлэх байр | |
|---|---|---|
| | Нэг хүнд ногдох ҮНО (ХАЧП-аар) | ХХИ |
| Молдав | 159 | 99 |
| Монгол | 152 | 100 |
| Узбекистан | 161 | 102 |

*Эх үүсвэр: Дэлхийн банк, "Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2012"*
*НҮБХХ , "Хүний хөгжлийн илтгэл – 2011"*

## II.1 Эдийн засгийн хөгжлийн үндсэн үзүүлэлтүүд

Эдийн засагт хөдөө аж ахуй, түүний дотор мал аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин өсөх нь улс орны эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх хандлагатай. ХАА-н салбар нь цаг агаарын болон байгалийн бусад хүчин зүйлээс ихээхэн хамааралтай, үр өгөөжийн хувьд буурах салбарт багтдаг бол харин үйлдвэрийн салбар нь нэмэгдэх үр өгөөжтэй салбарт ордог.

Манай улсын хувьд 2010 оны байдлаар ДНБ-д боловсруулах үйлдвэр болон үйлчилгээний салбарын эзлэх хувийн жин дундаж орлоготой орнуудын түвшнээс доогуур байна.

Хүснэгт 3

## Дотоодын нийт бүтээгдэхүүний салбарын бүтэц, хувиар, 2010 оны байдлаар

| | ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь | ДНБ-д үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь | ДНБ-д боловсруулах үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь | ДНБ-д үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 25 | 25 | 14 | 50 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 10 | 36 | 20 | 55 |
| Молдав | 14 | 13 | 13 | 73 |
| Монгол | 16 | 38 | 7 | 46 |
| Узбекистан | 20 | 35 | 9 | 45 |
| Өндөр орлоготой орнуудын дундаж | 1 | 24 | 15 | 75 |
| Дэлхийн дундаж | 3 | 25 | 16 | 72 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2012”

ДНБ-д хөдөө аж ахуйн салбарын эзлэх хувийн жин 2010 оны байдлаар дундаж орлоготой орнуудад 10 хувь байгаа бол манай улсын хувьд 16 хувь буюу 6 пунктээр өндөр байна. Хөгжлийн түвшин ахих тусам ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах зүй тогтолтой байдаг. Гэвч манай улсын хувьд ХАА-н салбар эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлсэн хэвээр байна.

Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийн жин манай улсын хувьд 2010 онд 38 хувь байгаа нь дундаж орлоготой орнуудынхаас 2 пунктээр өндөр байна. Хөгжлийн ижил түвшний Молдав улсад үйлдвэрлэлийн болон боловсруулах салбарын ДНБ-д эзлэх хувь харьцангүй бага, харин үйлчилгээний салбар өндөр хувийн жин эзэлж байна. Манай улсын хувьд боловсруулах салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувь дундаж орлоготой орнуудынхаас 2.9 дахин доогуур байгаа нь цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг хурдацтай хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Манай улсын үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн ДНБ-д эзлэх хувийн жин боловсруулах салбарынхтай адил дэлхийн дундаж, дундаж орлоготой орнуудын түвшнээс доогуур байна.

Зураг 1

## Хөгжиж буй орнуудын ДНБ-ий салбарын бүтэц, бүс нутгаар, 2010 оноор



Хөгжиж буй орнуудын ДНБ-ий салбарын бүтцийг бүс нутгаар авч үзвэл Латин Америк, Карибын тэнгисийн орнууд болон Европ, Төв Азийн орнуудад ДНБ-ий 60-аас илүү хувь нь үйлчилгээний салбарт ногдож байна.

Монгол Улсын хувьд ч үйлчилгээний салбарын цар хүрээ үйлдвэрлэлийнхээс хурдацтай нэмэгдэж, 2011 онд ДНБ-ий 51.5 хувьд хүрсэн.

ДНБ-ий бодит өсөлтийг 1990, 1995, 2000, 2005-2011 оноор хөгжлийн ижил түвшний улсууд болон дэлхийн дундаж, бага болон дундаж орлоготой орнуудын дундажтай харьцуулж үзвэл:

Хүснэгт 4

**Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт (бууралт), хувиар**

| | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 2.8 | 4.5 | 3.5 | 7.0 | 6.2 | 6.3 | 5.7 | 4.7 | 6.0 | 6.0 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 1.9 | 3.8 | 5.4 | 7.2 | 8.2 | 8.7 | 5.7 | 2.6 | 7.7 | 6.3 |
| Молдав | -2.4 | -1.4 | 2.1 | 7.5 | 4.8 | 3.1 | 7.8 | -6.0 | 7.1 | 6.4 |
| Монгол | -3.2 | 6.4 | 1.1 | 7.3 | 8.6 | 10.2 | 8.9 | -1.3 | 6.4 | 17.3 |
| Узбекистан | 1.6 | -0.9 | 3.8 | 7.0 | 7.3 | 9.5 | 9.0 | 8.1 | 8.5 | 8.3 |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 3.2 | 2.7 | 3.9 | 2.5 | 2.9 | 2.7 | 0.1 | -3.7 | 3.3 | 1.5 |
| Дэлхийн дундаж | 3.0 | 2.9 | 4.2 | 3.5 | 4.0 | 3.9 | 1.3 | -2.2 | 4.3 | 2.7 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Сүүлийн жилүүдэд хөгжиж байгаа орнуудын ДНБ-ий бодит өсөлтийн хурд дэлхийн дунджаас 3 гаруй дахин илүү байгаа бол өндөр орлоготой орнуудын өсөлт саарсан байна.
Эдийн засгийн өсөлтийг үйлдвэрлэлийн салбар тус бүрээр авч үзвэл:
Манай улсын хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт 2011 онд 0.3 хувь болж, өсөлтийн хурд өмнөх оныхоос нэмэгдсэн хэдий ч дундаж орлоготой орнуудтай харьцуулахад 3 пунктээр доогуур байна.

Хүснэгт 5

**Хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт (бууралт), хувиар**

| | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 4.3 | 3.5 | 1.5 | 4.7 | 4.3 | 4.2 | 3.3 | 3.6 | 5.0 | 4.8 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 4.2 | 1.9 | 2.3 | 3.9 | 4.3 | 3.4 | 3.8 | 2.1 | 3.9 | 3.3 |
| Молдав | .. | 7.4 | 2.3 | 1.5 | -2.8 | -30.0 | 41.6 | -16.9 | 7.2 | 0.0 |
| Монгол | 17.0 | 0.2 | -16.3 | 11.3 | 6.5 | 14.4 | 4.7 | 3.6 | -16.6 | 0.3 |
| Узбекистан | 5.8 | 2.0 | 3.2 | 6.2 | 6.2 | 6.1 | 4.5 | 5.7 | 6.1 | 4.0 |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 2.1 | -2.4 | 3.9 | 1.5 | -1.3 | -2.4 | 4.7 | 2.7 | -2.5 | .. |
| Дэлхийн дундаж | 3.3 | 0.3 | 2.9 | 3.0 | 2.3 | 1.3 | 4.1 | 2.3 | 1.8 | .. |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн өсөлт 2011 онд хөгжиж байгаа орнуудад / бага болон дундаж орлоготой орнууд/ 7.1-8.1 хувь, харин өндөр орлоготой орнуудад 2010 оны байдлаар 7.9 хувь байна. Манай улсын хувьд үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртөг 2011 онд 10.1 хувиар нэмэгдсэн нь уул уурхай, олборлох үйлдвэрлэлийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Хүснэгт 6

**Үйлдвэрлэлийн салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт (бууралт), хувиар**

| | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 0.2 | 5.0 | 3.9 | 7.5 | 9.2 | 7.4 | 6.0 | 4.5 | 7.0 | 8.1 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 2.5 | 5.6 | 6.4 | 8.1 | 9.0 | 9.4 | 5.8 | 2.9 | 9.5 | 7.1 |
| Молдав | .. | -28.9 | 6.6 | 2.6 | -3.9 | -6.8 | 1.2 | -17.5 | 9.5 | 0.0 |
| Монгол | -27.7 | 28.4 | 1.5 | 4.2 | 6.3 | 7.0 | -0.8 | -0.4 | 4.3 | 10.1 |
| Узбекистан | 1.6 | -5.2 | 1.8 | 5.0 | 4.5 | 6.6 | 6.8 | 4.1 | 8.3 | 5.0 |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 3.1 | 2.9 | 3.7 | 1.2 | 2.9 | 2.9 | -2.2 | -9.9 | 7.9 | .. |
| Дэлхийн дундаж | 3.0 | 3.4 | 4.3 | 3.0 | 4.5 | 4.7 | 0.1 | -6.0 | 8.5 | .. |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Ерөнхийдөө бага орлоготой орнуудын хувьд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт өндөр байгаа бол улс орнуудын хөгжлийн түвшин нэмэгдэхийн хэрээр өсөлтийн хурдац буурах хандлага ажиглагдаж байна.

Хүснэгт 7

**Үйлчилгээний салбарын нэмэгдэл өртгийн бодит өсөлт (бууралт), хувиар**

| | 1990 | 1995 | 2000 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 3.0 | 4.1 | 5.0 | 6.2 | 7.4 | 7.8 | 6.8 | 6.1 | 6.7 | 6.1 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 2.7 | 3.1 | 6.7 | 7.5 | 8.3 | 9.4 | 6.9 | 3.3 | 6.9 | 6.9 |
| Молдав | .. | 1.9 | -3.8 | 8.7 | 12.2 | 23.9 | -2.1 | 6.0 | 4.8 | -13.1 |
| Монгол | 3.5 | -7.8 | 10.5 | 9.7 | 7.6 | 11.9 | 16.6 | 0.8 | 9.8 | 17.1 |
| Узбекистан | -8.4 | -0.9 | 5.4 | 8.0 | 10.1 | 14.8 | 13.1 | 11.7 | 10.8 | 10.5 |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 3.4 | 2.7 | 4.0 | 2.9 | 2.9 | 2.7 | 0.7 | -2.0 | 2.2 | .. |
| Дэлхийн дундаж | 3.3 | 2.7 | 4.4 | 3.6 | 3.8 | 3.8 | 1.8 | -1.0 | 3.2 | .. |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Манай улсын инфляцийн жилийн дундаж түвшин 2011 онд өмнөх оныхоос 0.6 пунктээр буурсан байна. Харьцуулалтад сонгож авсан Молдав улсын инфляцийн жилийн дундаж түвшин манай улсынхаас 1.9 пунктээр доогуур буюу 7.6 хувь байна.

Хүснэгт 8

## Инфляцийн түвшин, хувиар

| | 2000 | 2005 | 2006 | 2007 | 2008 | 2009 | 2010 | 2011 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бага орлоготой орнуудын дундаж | 3.8 | 7.8 | 7.3 | 8.1 | 11.1 | 4.7 | 5.7 | 8.4 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 4.6 | 4.9 | 5.6 | 6.1 | 10.4 | 3.7 | 4.4 | 5.9 |
| Молдав | 31.3 | 12.0 | 12.8 | 12.4 | 12.8 | -0.1 | 7.4 | 7.6 |
| Монгол | 11.6 | 12.7 | 5.1 | 9.0 | 25.1 | 6.3 | 10.1 | 9.5 |
| Узбекистан* | 24.9 | 7.8 | 8.7 | 6.1 | 7.2 | 7.8 | 7.6 | 7.3 |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 2.5 | 2.5 | 2.5 | 2.5 | 4.3 | 1.2 | 2.0 | 3.3 |
| Дэлхийн дундаж | 3.5 | 4.1 | 4.4 | 5.0 | 9.0 | 2.9 | 3.5 | 4.9 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/
*- Азийн хөгжлийн банк, http:// sdbs.adb.org/

ДНБ-д улсын төсвийн орлого, зарлагын эзлэх хувь нь эдийн засаг дахь төрийн оролцоог харуулна. Засгийн газрын зардал ДНБ-ий 30 хувиас давах нь урт хугацаанд эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөөлдөг болохыг алдарт эдийн засагч, судлаач R.J.Barro эмпирик судалгаагаар нотолсон байдаг. Дэлхийн дунджаар 2010 онд ДНБ-д улсын төсвийн орлогын эзлэх хувь 23.8 хувь, ДНБ-д улсын төсвийн зарлагын эзлэх хувь 31.1 байгаа бол манай улсын хувьд 2010 онд орлогынх 33.7 хувь, зарлагынх 26.6 хувь байна.

Хүснэгт 9

## Улсын төсвийн орлого, зарлагын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь, 2010 оноор

| | ДНБ-д эзлэх хувь | |
|---|---|---|
| | Улсын төсвийн орлого | Улсын төсвийн зарлага |
| Бага орлоготой орнуудын дундаж | .. | .. |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 18.8 | .. |
| Молдав | 31.6 | 35.0 |
| Монгол | 33.7 | 26.6 |
| Узбекистан | .. | .. |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 24.9 | 32.2 |
| Дэлхийн дундаж | 23.8 | 31.1 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, “Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд-2012”

Хөгжиж байгаа дийлэнх орнууд ихээхэн хэмжээний хуримтлагдсан гадаад өртэй байдаг. Манай улсын хувьд 2010 оны байдлаар нийт гадаад өрийн хэмжээ 2.4 тэрбум ам.долл болж, үндэсний нийт орлогын 44.3 хувьд хүрсэн. Гадаад өрийн ҮНО-д эзлэх хувь 70 хувиас давах нь эдийн засагт дарамт үүсч байгаагийн нэг шинж байдаг онцлогтой.

Хүснэгт 10

**Гадаад өр, 2000, 2005, 2010 оноор**

| | Гадаад өрийн хэмжээ, сая ам.долл | | | Гадаад өрийн ҮНО-д эзлэх хувь | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 2000 | 2005 | 2010 | 2000 | 2005 | 2010 |
| Бага орлоготой орнуудын дундаж | 108371 | 117997 | 116593 | 67.6 | 50.8 | 28.5 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 2017980 | 2396068 | 3959705 | 36.9 | 26.1 | 20.8 |
| Молдав | 1690 | 2051 | 4615 | 129.0 | 61.3 | 73.5 |
| Монгол | 896 | 1327 | 2444 | 79.2 | 53.7 | 44.3 |
| Узбекистан | 4633 | 4282 | 7404 | 34.2 | 30.0 | 19.0 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

## II.2 Нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүд

Тухайн улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлт нь хамгийн бага, хүний хөгжлийн түвшингээрээ доогуур улс орнуудыг буурай хөгжилтэй орнуудын тоонд оруулдаг байна.

Манай улс Дэлхийн банкны ангиллаар дунджаас доогуур орлоготой орнуудын ангилалд багтдаг, далайд гарцгүй хөгжиж буй орон гэж тодорхойлогддог. НҮБ-аас гаргасан Дэлхийн хүний хөгжлийн илтгэлүүд, Дэлхийн банкнаас гаргасан Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд зэрэг жил бүр гаргадаг цуврал эмхтгэлүүд нь Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн зарим гол үзүүлэлтийг дэлхийн дундаж болон дунджаас доогуур орлоготой орнуудын дундаж үзүүлэлттэй харьцуулан үзэх боломжийг олгож байна. Эдгээр эмхтгэлийн үзүүлэлт нь 2008-2011 оны байдлаар гаргасан үзүүлэлтүүд юм. Сүүлийн жилүүдэд олон улсын байгууллагууд нийгмийн хөгжлийн үзүүлэлтүүдийг Мянганы Хөгжлийн зорилттой уялдуулан боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг голлон авч үзэх болсон байна.

Монгол Улсын анхны “Хүний Хөгжлийн Илтгэл”-ийг Монгол дахь НҮБХХ-ийн газрын дэмжлэгтэйгээр 1997 оны байдлаар гаргасан байна. Үүнээс хойш 2000 онд “Төрийг шинээр зүглэхүй”, 2003 онд “Хот, хөдөөгийн ялгаатай байдал”, 2007 онд “Ажилгүйдэл ба ядуурал”, 2011 онд “Эмзэг байдлаас тогтвортой хөгжил рүү” сэдвээр энэхүү илтгэлүүдийг гаргажээ.

Хүснэгт 11

## Хүний хөгжлийн үзүүлэлтүүд

| | Хүний хөгжлийн индекс (ХХИ) | Хүний хөгжлийн индексийн эрэмбэ | Дундаж наслалт | Сургуульд суралцсан дундаж хугацаа | Сургуульд суралцахаар хүлээгдэж буй хугацаа | Нэг хүнд ногдох ҮНО (худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн доллар) |
|---|---|---|---|---|---|---|
| Монгол | 0.653 | 110 | 68.5 | 8.3 | 14.1 | 3391 |
| Молдав | 0.649 | 111 | 69.3 | 9.7 | 11.9 | 3058 |
| Узбекистан | 0.641 | 115 | 68.3 | 10.0 | 11.4 | 2967 |
| Хүний хөгжлөөр маш өндөр | 0.889 | - | 80.0 | 11.3 | 15.9 | 33352 |
| Хүний хөгжлөөр өндөр | 0.741 | - | 73.1 | 8.5 | 13.6 | 11579 |
| Хүний хөгжлөөр дунд | 0.630 | - | 69.7 | 6.3 | 11.2 | 5276 |
| Хүний хөгжлөөр доогуур | 0.456 | - | 58.7 | 4.2 | 8.3 | 1585 |
| Дэлхийн дундаж | 0.682 | - | 69.8 | 7.4 | 11.3 | 10082 |

Эх үүсвэр: НҮБХХ , Хүний хөгжлийн илтгэл – 2011

НҮБ эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд хүний хөгжил улам бүр чухал болж байгааг тодохойлох зорилгоор үндэсний хүний хөгжлийн илтгэлийг гаргаж байхыг гишүүн орнуудаа уриалан, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (НҮБХХ) 1990 онд дэлхийн хүний хөгжлийн анхны илтгэлийг боловсруулсан байна.

Мөн үүнээс гадна Дэлхийн 189 орны төр, засгийн тэргүүн оролцсон НҮБ-ын Мянганы дээд хэмжээний уулзалтаар 2000 оны 9 дүгээр сард “Мянганы тунхаглал” баримт бичгийг баталсан. Энэхүү баримт бичигт 2015 он хүртэлх хугацаанд шийдвэрлэвэл зохих ядуурал, эрүүл мэнд, боловсрол, хүрээлэн буй орчин, хөгжлийн төлөө дэлхий нийтийн түншлэлийн хүрээнд тулгамдаж буй асуудлуудыг багцлан 8 зорилго, 18 зорилтын 48 шалгуур үзүүлэлттэйгээр дэвшүүлэн баталсан билээ. Дэлхийн улс орнудын нийгэм, эдийн засгийн нийтлэг болон өвөрмөц онцлогийг харгалзан үзэх шаардлагад нийцүүлэн Мянганы хөгжлийн дээрх зорилтуудыг өргөжүүлж, эдүгээ 8 зорилго, 21 зорилт, 60 шалгуур үзүүлэлттэйгээр шинэчлэгдэн батлагдаж, 2008 оны 1 дүгээр сарын 15-наас эхлэн мөрдөж байна.

Хүний хөгжлийн илтгэлийн үндсэн үзүүлэлтийн нэг нь хүний хөгжлийн индекс бөгөөд 2009 оны байдлаар Монгол хүний хөгжлийн индекс 0.642 байсан бол дэлхийн “Хүний хөгжлийн илтгэл 2011”-д үзүүлснээр нь Монгол хүний хөгжлийн индекс 2011 онд 0.653 байгаа нь дундаж хүний хөгжилтэй орнуудын дунджаас 0.023-аар өндөр байна.

Гэвч нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ /худалдан авах чадварын паритетаар илэрхийлсэн/ 3391 доллар байгаа нь дундаж хүний хөгжилтэй орнуудын дунджаас 1885 доллараар бага байна. “Хүний хөгжлийн илтгэл 2011”-д үзүүлснээр Монгол Улс хүний хөгжлийн индексээрээ 110-р байранд байна.

Дэлхийн хүн амын өсөлт 1990 онд 1.7 хувь байснаа 2011 онд 1.2 хувь болж, өсөлтийн хурдац 0.5 пунктээр саарчээ. Манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2011 онд 1990 оны түвшнээс 0.4 пункт, Молдавынх 0.5 пунктээр буурчээ. Манай улсын хүн амын жилийн дундаж өсөлт 2011 оны байдлаар дундаж орлоготой орнуудын дунджаас 0.5 пункт, өндөр орлоготой орнуудын дунджаас 1.0 пунктээр өндөр байна.

Зураг 2

## Хүн амын жилийн дундаж өсөлт




Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Манай улсын хувьд дунд, дээд боловсролын сургуульд суралцагч эмэгтэйчүүдийн тоо, эрэгтэйчүүдийнхээс өндөр байдаг бол бага орлоготой орнуудын дунджаар энэ нь эсрэг хандлагатай байна.

Хүснэгт 12

## Сургуульд суралцагчдын хүйсийн харьцаа, 2010 оноор

| | Сургуульд суралцагч эмэгтэй эрэгтэйчүүдийн тооны харьцаа | | |
|---|---|---|---|
| | Бага | Дунд | Дээд |
| Бага орлоготой орнуудын дундаж | 94.7 | 86.6 | 64.6 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 97.9 | 97.8 | 104.8 |
| Молдав | 99.6 | 102.4 | 133.6 |
| Монгол | 97.9 | 107.4 | 153.5 |
| Узбекистан | 97.5 | 98.6 | .. |
| Өндөр орлоготой оруудын дундаж | 99.4 | 99.6 | 124.3 |
| Дэлхийн дундаж | 97.5 | 96.9 | 107.9 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Манай улсын 100 000 хүн тутамд ногдох сүрьеэгийн өвчлөлийн түвшин 2011 онд дундаж орлоготой орнуудын түвшнээс 92 тохиолдлоор өндөр байна.

Улаан бурхны эсрэг урьдчилан сэргийлэх тарилгад 2010 оны байдлаар 12-23 сартай хүүхдүүдийн 97.0 хувийг хамруулсан нь дэлхийн дундажтай харьцуулахад ихээхэн өндөр үзүүлэлттэй байна.

Хүснэгт 13

## Эрүүл мэндийн салбарын зарим үзүүлэлтүүд

| | Сүрьеэгийн өвчлөлийн түвшин (100 000 хүнд ногдох) | | Улаан бурханы эсрэг урьдчилан сэргийлэх тарилганд хамрагдсан 12-23 сартай хүүхэд (%) | | Нялхсын эндэгдэл (1 000 амьд төрөлт) | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (1 000 амьд төрөлт) | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2008 | 2010 | 2008 | 2010 | 2008 | 2011 | 2008 | 2011 |
| Бага орлоготой орнуудын дундаж | 271 | 264 | 76.1 | 78.0 | 68.2 | 62.8 | 104.3 | 94.9 |
| Дундаж орлоготой орнуудын дундаж | 137 | 132 | 84.0 | 86.0 | 38.1 | 34.7 | 51.5 | 46.3 |
| Молдав | 175 | 182 | 94.0 | 97.0 | 15.2 | 13.8 | 17.7 | 16.0 |
| Монгол | 222 | 224 | 97.0 | 97.0 | 30.7 | 25.5 | 37.6 | 30.7 |
| Узбекистан | 128 | 128 | 98.0 | 98.0 | 43.7 | 41.5 | 51.3 | 48.6 |
| Өндөр орлоготой орудын дундаж | 15 | 14 | 92.8 | 93.4 | 5.4 | 5.0 | 6.4 | 5.9 |
| Дэлхийн дундаж | .. | .. | 83.5 | 85.3 | 40.4 | 36.9 | 56.8 | 51.4 |

Эх үүсвэр: Дэлхийн банк, http://data.worldbank.org/

Манай улсын нялхсын болон 5 хүртэлх насны хүүхдийн 1 000 амьд төрөлтөд ногдох эндэгдлийн тоо дундаж орлоготой орнуудын дунджаас доогуур байгаа хэдий ч өндөр орлоготой орнуудын дундажтай харьцуулбал харьцангүй өндөр байна.

Ашигласан ном, материал


- “World development indicators – 2012” - WB
- “World Economic Prospects – 2012” – WB
- “Human Development Report-2011” – UNDP
- http://data.worldbank.org/ , WB
- http:// sdbs.adb.org/, ADB
- “Статистикийн эмхтгэл - 2011” - ҮСХ

## Дэлхийн эдийн засаг, гадаад зах зээлийн тойм

### АНУ-ын эдийн засаг

АНУ-ын Эдийн засгийн шинжилгээний товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 10 дугаар сарын 26-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 2.0 хувиар* өсчээ[1].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.6, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 хувиар өсчээ[2].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 8 сард 374.4 тэрбум ам.долларын* алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 5.2 тэрбум ам.долл буюу 1.4 хувиар* өсчээ[3].

Тус улсын Холбооны нөөцийн сан (Төв банк)-гийн урьдчилсан тооцоогоор аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.4 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.8 хувиар өссөн байна[4].

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 10 дугаар сард 7.9 хувь* болж, өмнөх сарынхаас 0.1 хувиар өсчээ2.

### Япон улсын эдийн засаг

Япон улсын Эдийн засаг, нийгмийн судалгааны институтийн урьдчилсан тооцоогоор (2012 оны 9 дүгээр сарын 10-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 2 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.2 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 0.7 хувиар өсчээ[5].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 9 дүгээр сард 99.6 (2010=100) байгаа нь өмнөх сарынхаас 0.1 хувиар өсч, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 хувиар буурчээ[6].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 4773.2 тэрбум иений алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 3391.1 тэрбум иен буюу 3.5 дахин өсчээ7.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 9 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх сарынхаас 4.1 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 8.1 хувиар буурчээ.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 9 дүгээр сард 4.2 хувь* болж, өмнөх сарынхтай ижил түвшинд байна[9].

## ХАВСРАЛТ

### Европын холбооны гишүүн орнуудын эдийн засаг

Европын холбооны статистикийн байгууллагын урьдчилсан тооцоогоор (2012 оны 9 дүгээр сарын 6-нд мэдээлснээр) тус холбооны гишүүн 27 орны зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 2 дугаар улиралд өмнөх улирлынхаас 0.1 хувь*, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 хувиар* буурсан байна.

Инфляцийн түвшин 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 0.6 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 2.7 хувиар нэмэгдсэн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 8 сард 71.6 тэрбум еврогийн алдагдалтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 56.8 тэрбум евро буюу 44.2 хувиар буурчээ.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 8 дугаар сард өмнөх сарынхаас 0.3 хувиар* өсч, өмнөх оны мөн үеийнхээс 1.8 хувиар буурсан байна.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 9 дүгээр сард урьдчилсан гүйцэтгэлээр 10.6 хувь болж, өмнөх сарынхтай ижил түвшинд**, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 пунктээр өсчээ[9].

### ОХУ-ын эдийн засаг

ОХУ-ын Эдийн засаг, хөгжлийн яамны урьдчилсан тооцоогоор (2012 оны 7 дугаар сарын 25-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 2 дугаар улиралд өмнөх оны мөн үеийнхээс 4.4 хувиар өссөн байна[10].

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 10 дугаар сард өмнөх сарынхаас 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 6.5 хувиар нэмэгджээ.

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 8 сард 132.9 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 5.2 тэрбум ам.долл буюу 4.1 хувиар нэмэгдсэн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн индекс 2012 оны 9 дүгээр сард өмнөх сарынхаас 1.0 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.0 хувиар өсчээ.

Ажилгүйдлийн түвшин 2012 оны 9 дүгээр сард 5.2 хувь болж, өмнөх сарынхтай ижил түвшинд байна[11].

***- Улирлын нөлөөллийг тооцсон***
*****- Европын холбооны статистикийн байгууллагын 2012 оны 10 дугаар сарын 31-нд мэдээлснээр***

## БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын Үндэсний статистикийн товчооны урьдчилсан тооцоогоор (2012 оны 10 дугаар сарын 25-нд мэдээлснээр) зэрэгцүүлэх үнээрх дотоодын нийт бүтээгдэхүүн 2012 оны 3 дугаар улиралд өмнөх улирлынхаас 2.2 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 7.7 хувиар өссөн байна.

Хэрэглээний үнийн индекс 2012 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 1.9 хувиар өсчээ[12].

Гадаад худалдааны тэнцэл 2012 оны эхний 8 сард 120.6 тэрбум ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үеийнхээс 31.8 хувиар өсчээ[13].

Аж үйлдвэрийн салбарын нэмэгдэл өртөг 2012 оны 9 дүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 9.2 хувиар өсчээ[12].

## Зэсийн үнэ

Лондонгийн металлын биржид 1 тонн цэвэр зэсийн үнэ 2012 оны 10 дугаар сард дунджаар 8069.52 ам.долл болж, өмнөх сарынхаас 1.15 ам.долл буюу 0.01 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 722.02 ам.долл буюу 9.8 хувиар өсчээ[14] /Зураг 1/.

## Алтны үнэ

Лондонгийн металлын биржид 1 унц алтны үнэ 2012 оны 10 дугаар сард дунджаар 1747.01 ам.долл болж, өмнөх сарынхаас 2.56 ам.долл буюу 0.1 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 81.80 ам.долл буюу 4.9 хувиар өсчээ[15]/Зураг 2/.

## Газрын тосны үнэ

Нью-Йоркийн худалдааны биржид 1 баррел газрын тосны үнэ 2012 оны 10 дугаар сард дунджаар 89.56 ам.долл болж, өмнөх сарынхаас 5.15 ам.долл буюу 5.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 2.71 ам.долл буюу 3.1 хувиар өсчээ[16] /Зураг 3/.

## Хөрөнгийн биржийн индекс

АНУ-ын хөрөнгийн биржийн Аж үйлдвэрийн Dow Jones индекс 2012 оны 10 дугаар сард дунджаар 13380.65 нэгж болж, өмнөх сарынхаас 37.85 нэгж буюу 0.3 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 1864.71 нэгж буюу 16.2 хувиар нэмэгджээ[17].

Токиогийн хөрөнгийн биржийн Nikkei-225 индекс 2012 оны 10 дугаар сард дунджаар 8827.39 нэгж болж, өмнөх сарынхаас 121.20 нэгж буюу 1.4 хувиар буурч, өмнөх оны мөн үеийнхээс 93.82 нэгж буюу 1.1 хувиар нэмэгджээ[17].

Зураг-1




Зураг-2




Зураг-3



Лондонгийн хөрөнгийн биржийн FTSE-100 индекс 2012 оны 10 дугаар сард дунджаар 5831.80 нэгж болж, өмнөх сарынхаас 26.36 нэгж буюу 0.5 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 423.19 нэгж буюу 7.8 хувиар нэмэгджээ[17].

**ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ИНДЕКС, сараар.**

нэгж

| Он | Аж үйлдвэрийн Dow Jones[1] | Nikkei-225[2] | FTSE-100[3] |
|---|---|---|---|
| 2011 I | 11802.37 | 10449.53 | 5971.59 |
| II | 12190.00 | 10622.27 | 6020.97 |
| III | 12081.48 | 9852.45 | 5856.92 |
| IV | 12434.88 | 9644.63 | 6007.86 |
| V | 12579.99 | 9650.78 | 5937.97 |
| VI | 12097.31 | 9541.53 | 5792.17 |
| VII | 12512.33 | 9996.68 | 5909.81 |
| VIII | 11326.62 | 9072.94 | 5271.31 |
| IX | 11175.45 | 8695.42 | 5228.49 |
| X | 11515.93 | 8733.56 | 5408.62 |
| XI | 11804.33 | 8506.11 | 5402.51 |
| XII | 12075.68 | 8507.32 | 5480.09 |
| 2011 I-XII | 11957.57 | 9429.30 | 5681.39 |
| 2012 I | 12550.89 | 8616.71 | 5694.45 |
| II | 12889.05 | 9242.33 | 5893.35 |
| III | 13079.47 | 9962.35 | 5875.40 |
| IV | 13030.75 | 9627.42 | 5725.58 |
| V | 12721.08 | 8842.54 | 5461.44 |
| VI | 12544.90 | 8638.08 | 5480.44 |
| VII | 12814.09 | 8760.68 | 5636.47 |
| VIII | 13135.12 | 8949.88 | 5796.95 |
| IX | 13418.50 | 8948.59 | 5805.44 |
| X | 13380.65 | 8827.39 | 5831.80 |

*Тайлбар:*
1. *АНУ-ын хөрөнгийн биржийн индекс*
2. *Токиогийн хөрөнгийн биржийн индекс*
3. *Лондонгийн хөрөнгийн биржийн индекс*

***Эх үүсвэр:***


1. *http://bea.gov*
2. *http://stats.bls.gov*
3. *http://www.census.gov/foreign-trade*
4. *http://www.federalreserve.gov*
5. *http://www.esri.cao.go.jp*
6. *http://www.stat.go.jp*
7. *http://www.customs.go.jp*
8. *http://www.meti.go.jp*
9. *http://epp.eurostat.ec.europa.eu*
10. *http://www.economy.gov.ru*
11. *http://www.gks.ru*
12. *http://www.stats.gov.cn*
13. *http://www.e-to-china.com*
14. *http://www.lme.com*
15. *http://www.lbma.org.uk*
16. *http://www.nymex.com*
17. *http://finance.yahoo.com*

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороонд хэвлэв.

Хаяг :
14200 Улаанбаатар, Монгол Улс
Засгийн Газрын III байр, Өрөө-113
http://www.nso.mn
E-mail: information@nso.mn,
nso@magicnet.mn
Факс: (976-11) 329271
Утас: 322424, 326414